

# ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЖУРАМ

## Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос олгох, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, хөрөнгө оруулалтын менежментийн компанид үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогч (цаашид нийтэд нь “МНБ” гэх)-ийг бүртгэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, түүний бүтэц зохион байгуулалт, сангийн хөрөнгө ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон санг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгахтай холбоотой харилцаа болон хамтын хөрөнгө оруулалтын сангийн хяналт, зохицуулалт болон сонирхолын зөрчилгүй байх, тохиромжтой этгээд байх шаардлагыг тогтоон хэрэгжүүлэх, хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүнд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, сангийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох зэрэг цогц харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү журамд хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос олгох, хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-нд бүртгүүлэх, хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, хөрөнгө оруулалтын менежментийн компанид үйлчилгээ үзүүлэх мэргэшсэн нягтлан бодогч (цаашид нийтэд нь “МНБ” гэх)-ийг бүртгэхэд тавигдах шаардлагыг тодорхойлох, бүртгэх, бүртгэлээс хасах, хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, түүний бүтэц зохион байгуулалт, сангийн хөрөнгө ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, үйл ажиллагааны талаарх мэдээлэл болон санг нэгтгэх, нийлүүлэх, татан буулгахтай холбоотой харилцаа болон хамтын хөрөнгө оруулалтын сангийн хяналт, зохицуулалт болон сонирхолын зөрчилгүй байх, тохиромжтой этгээд байх шаардлагыг тогтоон хэрэгжүүлэх, хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүнд тавигдах нийтлэг болон тусгай шаардлага, сангийн зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоохтой харилцаанаас бусад харилцаанд хамаарахгүй.

1.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан зохицуулалттай этгээдэд хамаарах гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын менежментийн компани Монгол Улсад хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах ажиллагааг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр эрхлэх ба уг бүртгэлийг гүйцэтгэхтэй холбоотой харилцааг бие даасан журмаар зохицуулна.

1.4. Гадаад улсад бүртгэлтэй хамтын болон хувийн хөрөнгө оруулалтын сан Монгол Улсад үйл ажиллагаа явуулахтай холбоотой харилцааг бие даасан журмаар зохицуулна.

1.5. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.4, 14.9-д заасан дараалалд үндэслэн дор дурдсан дарааллаар гүйцэтгэнэ (хамтын). Үүнд:

1.5.1. хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх;

1.5.2. хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулах, үүсгэн байгуулах шийдвэр гарган, сангийн дүрмийг батлах, эрх бүхий албан тушаалтныг томилох;

1.5.3. хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

1.5.4. хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээг байгуулах;

1.5.5. хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалахтай холбоотой хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээг байгуулах;

1.5.6. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.9.2-14.9.3-д заасан үйл ажиллагааг гүйцэтгэх.

1.6. Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг үндэслэн дор дурдсан дарааллаар гүйцэтгэнэ (хувийн).

Үүнд:

1.6.1. хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлэх;

1.6.2. хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлсний үндсэн дээр хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулах, үүсгэн байгуулах шийдвэр гарган, сангийн дүрмийг батлах, эрх бүхий албан тушаалтныг томилох;

1.6.3. хувийн хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх;

1.6.4. хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээг байгуулах;

1.6.5. хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалахтай холбоотой хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээг байгуулах;

1.6.6. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах баримт бичиг, дүрэмд заасан хөрөнгө оруулалтыг татан төвлөрүүлж дуусгах, энэ талаар Хороонд мэдэгдсэний үндсэн дээр сангийн үйл ажиллагааг эхлүүлэх.

1.7. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг гагцхүү хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ. /цаашид “үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани” гэх/

1.8. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.10-т заасны дагуу энэхүү журмын 1.5-д заасан үйл ажиллагаа бүрэн хийгдсний дараа хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагдсанд тооцно.(хамтын)

1.9. Хувийн хөрөнгө оруулалтын санг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.12-т заасны дагуу хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэснээр үүсгэн байгуулагдсанд тооцно.(хувийн)

1.10. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.14-т заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх гагцхүү Хорооноос хөрөнгө

оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон өдөр үүсэх бөгөөд уг хуулийн 14.9.1 болон энэхүү журмын 1.5.3-д заасны дагуу тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэх нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулах эрх олгосон гэж үзэх үндэслэл болохгүй. (хамтын)

1.11. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.15-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сан хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдэх хүртэлх үүсгэн байгуулахтай холбоотой ажиллагааг тухайн хөрөнгө оруулалтын санг төлөөлж үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний томилсон эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэх ба хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүргэснээс хойших ажиллагааг тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх бүхий албан тушаалтан гүйцэтгэнэ. (хамтын)

1.12. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн бусдаас татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээ 1 /нэг/ тэрбум төгрөг байна. (хамтын)

1.13. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь 5 буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй нь Компанийн тухай хууль болон дүрмээр тогтоосон шаардлага хангасан хараат бус гишүүн байна. (хамтын)

1.14. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх мэргэшсэн нягтлан бодогч нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан бусад дүрэм, журам, зааврын хүрээнд ажиллана.

1.15. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайланг гаргах, тайлагнах этгээд нь мэргэшсэн нягтлан бодогч байна.

1.16. Хороонд бүртгүүлсэн мэргэшсэн нягтлан бодогч нь Хорооноос зөвшөөрсөн хугацаанд үйлчилгээ үзүүлэх эрхтэй байна.

1.17. Хороонд бүртгэлгүй болон энэхүү журмын шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон этгээдийн гаргасан санхүүгийн тайланг Хороо хүлээн зөвшөөрөхгүй.

## **ХОРООНД БҮРТГЭХ БА ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ**

### **БҮЛЭГ 1. ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГ ҮҮСГЭН БАЙГУУЛАХ, ХАМТЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ(ХАМТЫН), ҮҮСГЭН БАЙГУУЛАХ БАРИМТ БИЧГИЙГ БҮРТГҮҮЛЭХ(ХУВИЙН) ТУХАЙ**

#### **Хоёр. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх**

2.1. Үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг дараах хэлбэрийн аль нэгээр зохион байгуулж болно:

2.1.1. хамтын хөрөнгө оруулалтын санг дангаар үүсгэн байгуулах;

2.1.2. хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах эрх бүхий өөр бусад хөрөнгө оруулалтын менежментийн компанитай гэрээний үндсэн дээр хамтран үүсгэн байгуулах.

2.2. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эхлүүлэхээс өмнө үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани дараах бэлтгэл ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

2.2.1. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах шийдвэр, дүрэм, багц журмын болон хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын төслүүдийг боловсруулах;

2.2.2. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн оноосон нэрийг сонгох, нэрийг баталгаажуулах;

2.2.3. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сан бусдаас хөрөнгө итгэмжлэн удирдах болон хөрөнгө хадгалах үйлчилгээ авахтай холбоотой гэрээ, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бусдад худалдахтай холбоотой гэрээний төслийг боловсруулах, холбогдох хэлэлцээрийг хийж гэрээний төслийг эцэслэн байгуулах бэлтгэлийг хангах;

2.2.4. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын бодлогыг тодорхойлоход шаардлагатай судалгааг гүйцэтгэх, судалгааны үр дүнд үндэслэн холбогдох тооцооллыг гүйцэтгэх, хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын төслийг боловсруулах;

2.2.5. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд холбоотой хууль, дүрэм, журмаар тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэх, санг үүсгэн байгуулсны дараа тэдгээрийг хангаж ажиллах боломжтой эсэхийг нягтлах, энэ талаар холбогдох нотлох баримт, дүгнэлтийг бэлтгэх.

2.3 Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бэлтгэлийг хангах явцад үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани дараах зарчмыг баримтална. Үүнд:

2.3.1. хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлэхгүйгээр хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурал зарлахгүй байх;

2.3.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүртэлх хугацаанд үүсгэн байгуулахаар ажиллаж байгаа хамтын хөрөнгө оруулалтын сангийн талаар нийтэд сурталчлах, танилцуулахгүй байх;

2.3.3. хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүртэлх хугацаанд аливаа хэлбэрээр үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг бусдад худалдах, эсхүл худалдахаар гэрээ байгуулах болон аливаа бусад хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлэхгүй байх.

2.4. Ххөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлэх хүсэлтэд доор дурдсан мэдээллийг тусгана:

2.4.1. тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг үүсгэн байгуулагч менежментийн компани нь гүйцэтгэх тухай шийдвэрийн талаарх мэдээлэл;

2.4.2. үүсгэн байгуулахаар төлөвлөж байгаа хөрөнгө оруулалтын сангийн төрөл;

2.4.3. үүсгэн байгуулахаар төлөвлөж байгаа хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг гүйцэтгэх хугацааны талаарх төлөвлөгөө /уг ажиллагааны нийт үргэлжлэх хугацаа нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.5-д заасан хугацаанаас ихгүй байна/;

2.4.4. үүсгэн байгуулахаар төлөвлөж байгаа хөрөнгө оруулалтын сангийн активын хэмжээ, нийтээс татан төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн хэмжээ /татан төвлөрүүлэхээр тооцсон нийт акивын хэмжээ нь энэхүү журмын 1.12-т заасан хэмжээнээс багагүй байна/;

2.4.5. хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс тухайн үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгийн хэмжээ, уг хөрөнгийг оруулах санхүүгийн чадавхын талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалт хийх хэлбэр;

2.4.6. үүсгэн байгуулах ажиллагааны нийт төсөв, гарсан зардал болон уг зардлыг хэрхэн санхүүжүүлэх, санхүүжилтийг гаргах санхүүгийн боломж, өөрийн хөрөнгийн хүрэлцээний талаарх мэдээлэл, үүсгэн байгуулах ажиллагааны явцад гаргах зардлыг хэрхэн буцаан төлөхөөр тооцсон тухай мэдээлэл;

2.4.7. үүсгэн байгуулах бичиг баримт, судалгааг гүйцэтгэхэд оролцсон албан тушаалтан, хууль зүйн, болон бусад үйлчилгээ үзүүлсэн хуулийн этгээд, мэргэжилтний холбогдох үйлчилгээг үзүүлэх эрх бүхий болон тохиромжтой этгээд мөн болох тухай мэдээлэл, тэдгээрийн гүйцэтгэсэн ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

2.4.8. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.7.6-д заасны дагуу Хорооноос ирүүлэхээр тогтоосон бусад мэдээлэл.

## 2.5. Энэхүү журмын 2.5-д заасан хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана:

2.5.1. хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх хүсэлтийг хянан шийдвэрлэхтэй холбоотой улсын тэмдэгтийн хураамж болон үйлчилгээний хөлсийг төлсөн баримт;

2.5.2. үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар, үйлчилгээ үзүүлж байгаа бусад хөрөнгө оруулалтын сан, хуулийн этгээдийн талаарх мэдээлэл;

2.5.3. үүсгэн байгуулах бичиг баримтын төсөл болох үүсгэн байгуулах гэрээ, үүсгэн байгуулах шийдвэр, дүрмийн төсөл;

2.5.4. хөрөнгө оруулалтын сангийн багц журмын төсөл болон хөрөнгө итгэмжлэн удирдах журмын төсөл, эрсдлийн удирдлагын журмын төсөл, хяналтын үйл ажиллагааны журмын төсөл, татан буулгах ажиллагааны зэрэг журмын төслүүд;

2.5.5. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримтын төсөл (үүнд хөрөнгө оруулалтын болон зээлтэй холбоотой эрх мэдлийн хуваарилалтын талаар тусгасан байна);

2.5.6. хөрөнгө оруулалтын менежментийн компанитай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээний төсөл;

2.5.7. кастодиантай байгуулах хөрөнгө хадгалах үйлчилгээний гэрээний төсөл;

2.5.8. хөрөнгө оруулалтын санг нэгээс дээш тооны хөрөнгө оруулалтын менежментийн компани хамтран үүсгэн байгуулж байгаа бол тэдгээрийн хооронд байгуулсан Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.2-т заасан гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

2.5.9. үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн дүрмийн нотариатаар баталгаажуулсан хүчин төгөлдөр хуулбар;

2.5.10. Үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сантай хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний гэрээ байгуулах хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үүсгэн

байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компаниас өөр хуулийн этгээд бол уг гэрээ байгуулах хуулийн этгээдийн дүрмийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

2.5.11. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн бизнес төлөвлөгөөний төсөл, уг төлөвлөгөөг боловсруулсан судалгааны тайлан;

2.5.12. кастодианы үйлчилгээг нэг этгээдээс авах тухай тодорхойлолт;

2.5.13. үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд болон үүсгэн байгуулах ажиллагааг гүйцэтгэж байгаа албан тушаалтан нь тохиромжтой этгээд мөн болох болон тэдгээрийн ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодохойлолт;

2.5.14. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг хоёроос доошгүй тооны мэргэжилтэн хариуцан ажиллах бөгөөд тэдгээр ажиллагсад нь тохиромжтой этгээд мөн болох тухай болон ур чадвар, туршлагын талаарх тодорхойлолт;

2.5.15. үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр ажиллуулахаар төлөвлөж байгаа этгээд нь тохиромжтой этгээд мөн болох болон тэдгээрийн ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт;

2.5.16. Хорооноос тогтоосон бусад мэдээлэл.

2.6. Хороо нь энэхүү журмын 2.4-2.5-д заасан хүсэлтийг хянан шийдвэрлэх явцад шаардагатай гэж үзсэн өөр бусад мэдээлэл, бичиг баримтыг хүсэлт гаргагчаас шаардан гаргуулах, үйл ажиллагаатай нь танилцах бүрэн эрхтэй.

2.7. Хороо хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгүүлэх хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор бүртгэх эсэх шийдвэрийг гаргах бөгөөд хугацааг хүсэлтэд тусгах болон түүнд хавсарган ирүүлэх баримт бичгийн бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс эхлэн тооцно.

2.8. Хороо энэхүү журмын 2.9-д заасан шийдвэрийн талаар хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

2.9. Хороо нь үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэхээр шийдвэрлэсэн эсхүл бүртгэхээс татгалзах шийдвэрийг Хорооны хурлаас гаргах бөгөөд уг шийдвэрийн талаар хүсэлт гаргагчид бичгээр мэдэгдэнэ.

2.10. Хороо энэхүү журмын 2.11-д заасны дагуу хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэхээс татгалзвал хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг дуусгавар болно.

2.11. Хүсэлт гаргагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь бичгээр хүсэлт гаргасан нөхцөлд Хорооноос хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэхээс татгалзсан талаарх тайлбарыг хүсэлт гаргагчид өгч болно.

2.12. Хороо хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэх нь тухайн бичиг баримтын агуулга, түүний дагуу үүсгэн байгуулах хөрөнгө оруулалтын сан болон үүсгэн байгуулах сангийн үйл ажиллагааг гүйцэтгэх хөрөнгө оруулалтын менежментийн компани,

түүний ажилтан, удирдлагын талаар ямар нэг баталгаа гаргасан гэж үзэх үндэслэл болохгүй ба тэдгээртэй холбоотой аливаа эрсдэл, алдагдал, хохирлыг Хороо хариуцахгүй.

2.13. Хороо хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг бүртгэсэн эсэхээс үл хамаарч хөрөнгө оруулагч болон хамтран ажиллах аливаа иргэн, хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын шийдвэрээ бие даан гаргаж өөрийн гаргасан шийдвэртэй холбоотой үүсэх аливаа үр дагаварыг өөрсдөө хариуцна.

2.14. Энэхүү журмын 2.5 болон 2.6 дахь заалтад заасан баримт бичгийг хянах явцад шаардлагатай гэж үзвэл Хороо холбогдох хөрөнгө оруулагчдад заавал мэдэгдэх мэдээллийн талаар шаардлагыг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанид тавьж болно.

### **Гурав. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах**

3.1. Энэхүү журмын 1.5.2-1.5.6-д заасан ажиллагааг хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлснээс хойш нэг сарын хугацаанд гүйцэтгэн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүсэлтийг гаргана.(хамтын)

3.2. Энэхүү журмын 3.1-д заасан хугацаанд үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргаагүй тохиолдолд тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг дуусгавар болгоно. (хамтын)

3.3. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлсний дараа тухайн санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулна. (хамтын)

3.4. Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь тухайн санг үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлснээс хойш 45 хоногийн хугацаанд уг хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулж хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ. (хувийн)

3.5. Энэхүү журмын 3.1-д заасан хугацаанд үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үүсгэн байгуулах хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг гаргаагүй тохиолдолд Хороонд бүртгүүлсэн үүсгэн байгуулах баримт бичгийн бүртгэлийг хүчингүй болсонд тооцно. (хувийн)

3.6. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлыг зарлан хуралдуулах ажиллагааг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.

3.7. Хамтын хөрөнгө оруулалтын санг нэгээс дээш тооны хөрөнгө оруулалтын менежментийн компани үүсгэн байгуулах тохиолдолд тэдгээр нь хоорондоо үүсгэн байгуулагчдын гэрээг байгуулна. (хамтын)

3.8. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлаар сан үүсгэн байгуулах шийдвэрээс гадна сангийн дүрмийг баталж төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох ба энэхүү журмын 5, 6 дугаар зүйлд заасан гэрээний төслүүдийг байгуулах эсэх шийдвэрийг гаргана.

3.9. Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлаар үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компаниас тухайн хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгийг тодорхойлох бөгөөд уг хөрөнгийг тусгайлсан дансанд бэлнээр байршуулсны үндсэн дээр холбогдох нэгж эрхийг хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эзэмшилд шилжүүлэн бүртгэж болно. (хамтын)

3.10. Энэхүү журмын 3.7-д зааснаас бусад тохиолдолд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороонд бүртгүүлэхээс өмнө тухайн хамтын хөрөнгө оруулалтын санд бусдаас хөрөнгө оруулалт татах, уг сангийн нэгж эрхийг бусдад худалдах болон тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь өөрийн эзэмшилд бүртгүүлсэн нэгж эрхийг бусдад худалдах, шилжүүлэхгүй. (хамтын)

3.11. Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах хурлаар үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани болон бусад хөрөнгө оруулагчдын зүгээс тухайн хөрөнгө оруулалтын санд оруулах хөрөнгийн хэмжээ, нэгж эрхийг худалдах үнийг тогтоох ба төлбөрийг кастодиан дахь тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэр дээр нээсэн дансанд тусгаарлан байршуулсан нөхцөлд сангийн нэгж эрхийг хөрөнгө оруулалтын менежментийн компани болон бусад хөрөнгө оруулагчдын эзэмшилд шилжүүлэн бүртгэнэ. (хувийн)

3.12. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн төлбөрийг тухайн сан болон түүнд үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компанийн данснаас тусгаарласан дансанд байршуулах бөгөөд тухайн хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлэх хүртэл тухайн сангийн нэр дээрх дансанд байршуулсан буюу сангийн нэгж эрхийг худалдан авахаар төлсөн хөрөнгийг зарцуулах эрх тухайн сан болон хөрөнгө оруулалтын менежментийн компанид нээгдэхгүй. (хувийн)

3.13. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг төлбөр хийгдсэний дараа нэгж эрхийг шилжүүлэх нөхцлөөр худалдана. (хувийн)

3.14. Энэхүү журмын 3.7-д заасан үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанид худалдах сангийн нэгж эрхийн үнэ нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг нийтэд санал болгон худалдах үнээс багагүй байна.

3.15. Энэхүү журмын 3.6-д заасан хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах шийдвэрийг гарган сангийн дүрмийг баталсны үндсэн дээр тухайн санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлнэ.



3.16. Хөрөнгө оруулалтын сангийн нэр нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 15.1-д заасны дагуу түүний оноосон нэр болон “хамтын хөрөнгө оруулалтын сан”, “хувийн хөрөнгө оруулалтын сан” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “Хамтын ХОС”, “Хувийн ХОС” гэсэн товчилсон тэмдэглэгээнээс бүрдэнэ.

3.17. Хөрөнгө оруулалтын сангийн оноосон нэр нь дараах шаардлагыг хангасан байна:

3.17.1. тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны чиглэлтэй нийцсэн байх;

3.17.2. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлого, танилцуулгад заасан мэдээллийн агуулгатай зөрчилдөөгүй байх;

3.17.3. хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах нь нэгж эрх эзэмшигчид эрсдэлгүй байх, эсхүл хэт өндөр буюу бодит бус өгөөжтэй байх зэрэг үндэслэлгүй, буруу, ташаа ойлголтыг нэгж эрх эзэмшсэн эсхүл эзэмших иргэн, хуулийн этгээдэд төрүүлэхгүй байх;

3.17.4. Монгол Улс болон өөр бусад орны хөрөнгө оруулалтын сангийн нэртэй давхардаагүй байх;

3.17.5. нийтээр хүлээн зөвшөөрсөн ёс суртахууны хэм хэмжээнд харшлаагүй байх.

3.18. Хамтын хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсний дараа тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг эцэслэн боловсруулж, уг танилцуулгыг тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулагч эсхүл бусад эрх бүхий этгээд Хороонд бүртгүүлэхээр хүргүүлнэ. (хамтын)

3.19. Хувийн хөрөнгө оруулалтын санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсний дараа тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн удирдлага нь энэ талаар Хороонд мэдэгдэж үүсгэн байгуулах ажиллагааны тайланг Хороонд хүргүүлсний үндсэн дээр тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг эхлүүлж болно. (хувийн)

3.20. Энэ журмын 3.19-т заасан тайланд дараах бичиг баримтыг хавсаргана(хувийн). Үүнд:

3.20.1. хувийн хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.20.2. энэхүү журмын 2.5, 2.6-д заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн баталсан эсхүл байгуулсан баримт бичгийн нотариатаар баталгаажуулсан хуулбар;

3.20.3. энэхүү журмын 2.5, 2.6-д заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох өөрчлөлтийн үндэслэлийн талаарх тайлбар;

3.20.4. энэхүү журмын 2.5 болон 2.6-д заасан хувийн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хамаарах эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн өөрчлөгдсөн эсэх, тэдгээр нь тохиромжтой этгээд мөн болох тухай болон ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт;

3.20.5. хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагаанд оролцсон иргэн, хуулийн этгээдийн жагсаалт, тэдгээрийн үйлдсэн судалгаа, тайлан, дүгнэлтийн талаарх мэдээлэл.

3.21. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг худалдах ажиллагааг дараах хэлбэрээр хөрөнгө төвлөрүүлэхийг хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах зорилгоор хөрөнгө татан төвлөрүүлсэн гэж үзэхгүй. (хувийн) Үүнд:

- 3.21.1. хөрөнгө оруулалтын бус зорилгоор буюу хадгаламж зээлийн эсхүл харилцах дансны нөхцлөөр хөрөнгө төвлөрүүлсэн;
- 3.21.2. хөрөнгө оруулалтын сангаас өөр бусад хөрөнгө оруулагчид захиран зарцуулах зориулалт бүхий дансанд хөрөнгө төвлөрүүлсэн;
- 3.21.3. өрийн бичиг, вексель, опцион зэрэг нэгж эрхээс бусад төрлийн үнэт цаас гаргах замаар хөрөнгө төвлөрүүлсэн;
- 3.21.4. нэгж эрх худалдахаас бусад хэлбэрээр төвлөрүүлсэн.

3.22. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

- 3.22.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хороо болон бусад эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны баталсан дүрэм, журмыг дагаж мөрдөх, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах;
- 3.22.2. эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж ажиллах;
- 3.22.3. хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, дүрэм, үүсгэн байгуулах гэрээнд заасан хязгаарын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;
- 3.22.4. хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэн тэргүүн ээлжинд ханган ажиллах.

#### **Дөрөв. Хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт**

4.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 16.1, Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд дараах зүйлийг тусгана. Үүнд:

- 4.1.1. хөрөнгө оруулалтын сангийн бүрэн болон товчилсон оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ;
- 4.1.2. хөрөнгө оруулалтын сангийн зарласан болон гаргасан нэгж эрхийн тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ, нэгж эрх бүрд хамаарах нэгж эрх эзэмшигчийн эрх, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
- 4.1.3. аливаа төрлийн нэгж эрхийг арилжих журам, тодорхой төрлийн нэгж эрхийг гаргахад мөрдөх хязгаарлалт;
- 4.1.4. хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо;
- 4.1.5. хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага болох нэгж эрх эзэмшигчдийн хурал, төлөөлөн удирдах зөвлөлийн хууль дүрмээр тодорхойлсон бүрэн эрх, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой зохицуулалт, эрх хэмжээний хязгаарлалт;
- 4.1.6. хөрөнгө оруулалтын сангийн дотоод хяналтын бүтэц зохион байгуулалт, үйл ажиллагааны журам;
- 4.1.7. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны чиглэл, хөрөнгө оруулалтын сан нь зөвхөн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх зорилготой байх тухай, хөрөнгө

оруулалтын зорилтуудтай холбоотой мэдээлэл, үүнд хөрөнгө оруулалтын эрсдлийг тараан байршуулах, хөрөнгө оруулах хөрөнгийн төрөл болон хөрөнгө оруулалт, зээл, үнэт цаасны зээлийн хязгаарлалт, түүнтэй холбоотой дэлгэрэнгүй мэдээлэл, эсвэл тийм хязгаарлалтгүй бол шалтгаан, үндэслэл;

4.1.8. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 16.1.2, 16.1.3, 16.1.5-16.1.7 болон 16.1.9-д заасан мэдээллийг тусгана

4.1.9 хөрөнгө оруулалтын сангийн орлого, түүний хувиарлалтын журам;

4.1.10. хөрөнгө оруулалтын сангийн зардлын төрөл, хэмжээ, тэдгээрийг зарлагдах журам;

4.1.11. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч нь тухайн сангийн өр төлбөр, бусдаас авсан зээлийг өөрийн хөрөнгөөр хариуцахгүй тухай;

4.1.12. нэгж эрх эзэмшигч өөрийн нэгж эрхийн төлбөрийг төлсний дараа аливаа төлбөр хийх үүрэг хүлээхгүй тухай;

4.1.13. хөрөнгө оруулалтын сангийн эрх бүхий албан тушаалтны үүрэг, хариуцлага;

4.1.14. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг түр зогсоох болон татан буулгах үндэслэл, энэ тохиолдолд нэгж эрх эзэмшигчийн эдлэх эрх, хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг үнэлэх тодорхойлох аргачлал;

4.1.15. хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах журам;

4.1.16. бусад.

4.3. Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 17.1-д заасан зүйлийг заавал тусгасан байна.

#### **Тав. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулах**

5.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний хугацаа нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаатай нэгэн адил байна.

5.2. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ нь Хорооны 20.. оны .. дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам”-ын .. дугаар зүйлд заасан шалгуур, шаардлагыг хангасан байна.

5.3. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг байгуулахдаа Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 47.2-д заасан үүргийг тусгах ба тус хуулийн 46.8 дах заалтыг удирдлага болгоно.

#### **Зургаа. Хөрөнгө хадгалах гэрээ байгуулах**

6.1. Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалахтай холбоотой кастодиантай байгуулах хөрөнгө хадгалах гэрээний хугацаа нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан сангийн үйл ажиллагаа эрхлэх хугацаатай нэгэн адил байна.

6.2. Хөрөнгө хадгалах гэрээ нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 46.5-д заасан Хороо болон Монголбанкнаас тогтоосон кастодианы үйл ажиллагааны журмаар тогтоосон шаардлагыг хангасан байна.

6.3. Хөрөнгө хадгалах гэрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасан зүйлийг заавал тусгана.

6.4. Хөрөнгө хадгалах гэрээнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 50.2 дах заалтаар хориглосон заалтуудыг тусгахгүй.

#### **Долоо. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга, түүнийг бүртгүүлэх (зөвхөн хамтын)**

7.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.11-д заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгад дор дурдсан мэдээллийг тусгана. Үүнд:

7.1.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, эрхлэх хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа, хөрөнгийн биржид бүртгүүлэх эсэх тухай;

7.1.2. нэгж эрх гаргагч хамтын хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр;

7.1.5. нэгж эрх гаргагч хамтын хөрөнгө оруулалтын сангийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, тэдгээрийн өмчлөл дэх нэгж эрхийн тоо, хувь хэмжээний талаарх мэдээлэл;

7.1.6. нэгж эрх гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, хэлцэл, тэдгээрийн хэрэгжилтийн тухай;

7.1.7. хамтын хөрөнгө оруулалтын сангийн холбогдох этгээдийн тухай;

7.1.8. нийтэд санал болгож байгаа нэгж эрхийн тоо, хэлбэр, нэрлэсэн үнэ, тэдгээрийг нийтэд санал болгох болон арилжих болон ногдол ашиг хуваарилах нөхцөл, журам;

7.1.9. нийтэд санал болгож байгаа нэгж эрхээр гэрчлэгдэх эрх, үүрэг;

7.1.10. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд учирч болох эрсдэл, эрсдэлийн удирдлагын төлөвлөгөө;

7.1.11. тухайн нэгж эрхийг нийтэд санал болгох ажиллагаанд хамтран оролцож хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианоос бусад зохицуулалттай этгээд болон бусад мэргэжлийн үйлчилгээ үзүүлж байгаа этгээдийн тухай, тэдгээртэй байгуулсан гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай;

7.1.12. хөрөнгө оруулалтын сангийн дүрэм;

7.1.13. хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг;

7.1.14. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа;

7.1.15. хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн мэдээлэл, тус компанитай байгуулсан хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлэх гэрээний хуулбар, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай, үйлчилгээний урамшуулал болон зардлын тооцоолол болон хөрөнгө итгэмжлэн удирдах ажиллагааг гүйцэтгэх эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл;

7.1.16. кастодианы үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн мэдээлэл, кастодиантай байгуулсан хөрөнгө хадгалах гэрээний хуулбар, гэрээгээр хүлээсэн эрх, үүрэг, хариуцлагын тухай, үйлчилгээний хөлсний хэмжээ, тооцоолол;

7.1.17. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулахтай холбоотой гарах бусад зардлын тооцоолол;

7.1.18. хамтын хөрөнгө оруулалтын сан төлбөрийн чадваргүй болох, алдагдал хүлээх тохиолдолд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагааны журам;

7.1.19. нэгж эрх эзэмшигчдэд өгөх мэдээлэл, санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан гаргах, тайланг нэгж эрх эзэмшигчдэд хүргэх журам болон нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах бусад зохицуулалт;

7.1.20. Хорооноос тогтоосон бусад мэдээлэл.

7.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгад дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

7.2.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

7.2.2. энэхүү журмын 2.4, 2.5-д заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн батлагдсан эсхүл байгуулсан баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;

7.2.2. энэхүү журмын 2.4, 2.5-д заасан төсөл хэлбэрээр Хороонд бүртгүүлсэн баримт бичгийн өөрчлөлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, холбогдох өөрчлөлтийн үндэслэлийн талаарх тайлбар;

7.2.3. энэхүү журмын 2.4 болон 2.5-д заасан хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд хамаарах эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэн өөрчлөгдсөн эсэх, тэдгээр нь тохиромжтой этгээд мөн болох тухай болон ур чадвар, туршлагын талаарх дэлгэрэнгүй тодорхойлолт;

7.2.4. нэгж эрхийн танилцуулгыг боловруулахад оролцсон иргэн, хуулийн этгээдийн жагсаалт, тэдгээрийн үйлдсэн судалгаа, тайлан, дүгнэлт.

7.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо хүсэлт хүлээн авснаас хойш ажлын 15 хоногийн дотор бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ. Энэхүү хугацааг бүрдэл бүрэн хангагдсан өдрөөс эхлэн тооцно.

7.4. Хороо нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх эсэх шийдвэр гаргахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай болон Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль тогтоомжийг үндэслэл болгоно.

7.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо бүртгэснээр тухайн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулж болно.

7.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд уг танилцуулгыг нийтэд танилцуулах, уг баримт бичигт заасан үндэслэлээр зөвхөн хөрөнгө татан төвлөрүүлнэ.

7.7. Хороо нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэхээс татгалзсан тохиолдолд уг шийдвэрийг гарсанаас хойш нэг сарын дотор тухайн санг татан буулгах ажиллагааг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани гүйцэтгэнэ.

7.8. Хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх хүсэлтийг шийдвэрлэх явцад шаардлагатай мэдээлэл, бичиг баримтыг хүсэлт гаргагчаас болон тухайн санд холбогдох үйлчилгээг үзүүлэхээр гэрээ байгуулсан буюу үйлчилгээ үзүүлсэн иргэн, хуулийн этгээдээс шаардах, шаардлагатай тохиолдолд шалгалт явуулж болно.

**Найм. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг нийтэд танилцуулах, хөрөнгө татан төвлөрүүлэх ( зөвхөн хамтын)**

8.1. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь нийтээс хөрөнгө оруулалт татах ажиллагааг сангийн нэгж эрхийн танилцуулгад үндэслэн хэрэгжүүлэх бөгөөд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах, хөрөнгө төвлөрүүлэхэд энэхүү журмыг баримтална.

8.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.2-т заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь тухайн санд хөрөнгө оруулалтын менежментийн үйлчилгээ үзүүлж болно.

8.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг нийтэд санал болгох ажиллагааг гүйцэтгэхдээ нэгж эрхийн танилцуулгыг сонирхогч этгээд үнэ төлбөргүйгээр танилцах боломжийг бүрдүүлнэ.

8.4. Хороо нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах ажиллагааны явцад хяналт, шалгалт хийх эрхтэй бөгөөд хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлөх буюу дутуу, худал, төөрөгдүүлэх, худал амлалт өгөх зэрэг нөхцөл байдал үүссэн нөхцөлд нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах ажиллагааг зогсоох буюу нэгж эрхийн танилцуулгын бүртгэлийг хүчингүй болгох арга хэмжээ авч болно.

8.5. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.4-т заасны дагуу хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах арилжааг үнэт цаасны арилжаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд бүртгүүлэх замаар зохион байгуулж болно. Энэ тохиолдолд холбогдох үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын дүрэм, журам, шаардлагад нийцүүлэн нэгж эрхийн танилцуулгыг нийтэд танилцуулах ажиллагааг гүйцэтгэнэ.

8.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд зөвхөн мөнгөн хөрөнгөөр худалдах ба дараах хэлбэрээр хөрөнгө төвлөрүүлэхийг хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах зорилгоор нийтээс хөрөнгө татан төвлөрүүлсэн гэж үзэхгүй. Үүнд:

8.6.1. хөрөнгө оруулалтын бус зорилгоор буюу хадгаламж эсхүл харилцах дансны нөхцлөөр хөрөнгө төвлөрүүлсэн;

8.6.2. нийтийн хэрэглээний зориулалт бүхий дансанд хөрөнгө байршуулах буюу тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангаас өөр бусад хөрөнгө оруулагчид захиран зарцуулах эрхтэй байх нөхцлөөр хөрөнгө төвлөрүүлсэн;

8.6.3. өрийн бичиг, вексель, опцион зэрэг нэгж эрхээс бусад төрлийн үнэт цаас гаргах замаар хөрөнгө төвлөрүүлсэн;

8.6.4. нэгж эрх худалдахаас бусад хэлбэрээр төвлөрүүлсэн.

8.7. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд зээлээр буюу төлбөрийг дараа хийх нөхцлөөр худалдах, эсхүл төлбөргүйгээр бусдад шилжүүлэхийг хориглох ба төлбөр хийгдсэний дараа нэгж эрхийг шилжүүлэх нөхцлөөр худалдана.

8.8. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрхээ анхдагч зах зээлд худалдах ажиллагааг энэхүү журмын 8.6-д заасан хугацаанд дуусгавар болгож нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааны тайланг ажлын 3 хоногт багтаан гаргаж уг тайланг хөрөнгө оруулагч болон Хороонд танилцуулах үүрэгтэй.

8.9. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь дүрэмд заасан хөрөнгөө нийтээс төвлөрүүлж чадсан нөхцөлд энэхүү журмын 8.9-д заасан тайланг гарган Хороонд хүргүүлэх ба хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтээ хамт гаргана.

8.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааны тайланг Хороо хянасны үндсэн дээр уг ажиллагаа амжилттай болсон эсэхийг шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг тухайн санд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох шийдвэртэй хамт гаргана.

8.11. Хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгохоос татгалзах шийдвэр гаргах нь уг сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцохоос татгалзах үндэслэл болно.

8.12. Хороо нэгж эрхийг андагч зах зээлд амжилттай болсонд тооцсон нөхцөлд тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлж болно.

8.13. Энэхүү журмын 8.11-д заасны дагуу Хороо хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг анхдагч зах зээлд худалдах ажиллагааг амжилттай болсонд тооцсоноор уг нэгж эрхийг худалдах, худалдан авах хэлцлийг хүчингүй болгохгүй.

8.14. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.6-д заасан хугацаанд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж чадаагүй тохиолдолд үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ тухай Хороонд мэдэгдэх үүрэг хүлээнэ.

8.15. Хороо нь энэхүү журмын 8.15-д заасан мэдэгдлийг хүлээн авч тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зогсоох тухай шийдвэр гаргах бөгөөд уг шийдвэр гарснаас хойш ажлын 15 өдөрт багтаан тухайн сан нь өөрийн дансанд хуримтлагдсан хөрөнгийг хөрөнгө оруулагчид буцаан олгох, бүртгэлээс хасуулж, татан буулгах ажиллагааг зохион байгуулна.

8.16. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.8-д заасны дагуу Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн төлбөрийг тухайн сан болон түүнд үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компанийн данснаас өөр дансанд байршуулна.

**Ес. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох**

9.1. “Хамтын хөрөнгө оруулалтын сан нь энэхүү журмын 8.10-т заасан хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авах өргөдлийг журмын хавсралт маягт ын дагуу гаргаж, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 27.2-т заасан баримт бичгээс гадна дараах бичиг баримтыг хавсаргана. Үүнд:

9.1.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан хөрөнгийг төвлөрүүлсэн тухай хөрөнгө хадгалах гэрээ байгуулсан кастодианы тодорхойлолт;

9.1.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэлийг хангасан болохыг илэрхийлэх баримт бичиг;

9.1.3. бусад.

9.2. Хороо нь хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 30 хоногийн дотор хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

9.3. Хороо нь дор дурдсан нөхцөл шаардлага хангагдсан нөхцөлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоно. Үүнд:

9.3.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 28.1-д заасан нөхцөл шаардлагыг хангасан;

9.3.2. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан хөрөнгийг тусгаарласан дансанд бүрэн төвлөрүүлсэн;

9.3.3. хамтын хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэх хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан болон үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд, мэргэжилтэн нь тохиромжтой этгээдийн болон тухайн үйл ажиллагаагаа эрхлэх нөхцөл, шаардлагыг хангаж байгаа;

9.3.4. хөрөнгө оруулагчдын эрх ашигт сөргөөр нөлөөлж болох буюу тусгай зөвшөөрөл олгохоос татгалзах өөр бусад үндэслэлгүй;

9.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэхэд дараах нөхцөл, шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

9.4.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хороо болон бусад эрх бүхий төрийн байгууллага, албан тушаалтны баталсан дүрэм, журмыг дагаж мөрдөх, үйл ажиллагаагаа хуулийн хүрээнд явуулах;

9.4.2. тохиромжтой этгээдийн шаардлагыг хангаж ажиллах;

9.4.3. хөрөнгө оруулалтын бодлогын бичиг баримт, дүрэм, нэгж эрхийн танилцуулгад заасан хязгаарын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах;

9.4.4. хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хүндэтгэн тэргүүн ээлжинд ханган ажиллах;

9.4.5. мэргэжлийн, хөрөнгө, техникийн болон бусад нөхцөл шаардлага, шалгуурыг хангаж ажиллах.

9.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 5 хоногийн дотор холбогдох бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн албанд бүртгүүлнэ.

9.6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29.1-д заасан үндэслэл тогтоогдсон нөхцөлд Хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

9.7. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, эсхүл хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах нөхцөл байдал үүссэн нөхцөлд хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг түдгэлзүүлж нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах бөгөөд энэ тухай Хороонд тухай бүр мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:



- 9.7.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын эрх бүхий албан тушаалтан, үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан нь тохиромжтой этгээдийн шаардлагыг хангахгүй болсон;
- 9.7.2. хамтын хөрөнгө оруулалтын санг татан буулгах нөхцөл байдал үүссэн;
- 9.7.3. нэгж эрх эзэмшигчдийн хурлыг заавал зарлан хуралдуулах нөхцөл байдал үүссэн;
- 9.7.4. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 29.1-д заасан нөхцөл байдал бий болсон.

9.8. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх үндэслэл арилсан буюу үйл ажиллагааг сэргээх боломжтой гэж Хороо үзсэн нөхцөлд тусгай зөвшөөрлийг сэргээх бөгөөд энэ тохиолдолд тусгай зөвшөөрлийн хүчинтэй хугацаа өөрчлөгдөхгүй, сунгахгүй.

9.9. Хороо дор дурдсан үндэслэлээр хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрийг хүчингүй болгож болно. Үүнд:

- 9.9.1. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.6-д заасан нөхцөл байдал үүссэн;
- 9.9.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 19.13-т заасан нөхцөл байдал үүссэн;
- 9.9.3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.6-д заасан хориглох үйл ажиллагааг эрхэлсэн;
- 9.9.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

9.10. Хамтын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох нь тухайн санг татан буулгах үндэслэл болох бөгөөд энэ тохиолдолд хөрөнгө оруулалтын менежментийн компани эсхүл тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх захирал нь нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг ажлын 15 хоногийн дотор зарлан хуралдуулж хамтын хөрөнгө оруулалтын санг татан буулгах ажиллагааг гүйцэтгэнэ.

9.11. Хороо нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх болон хүчингүй болгох тухай шийдвэрийг өөрийн цахим хуудсанд байршуулах замаар нийтэд мэдээлнэ.

## БҮЛЭГ 2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧДЫГ БҮРТГЭХ ТУХАЙ

### **Арав. МНБ-ийн баримтлах зарчим**

10.7. Хороонд бүртгүүлсэн МНБ нь Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан Нягтлан бодох бүртгэлийн зарчмаас гадна дараах нийтлэг зарчмыг чанд баримтлана. Үүнд:

- 10.7.1. Монгол Улсын хууль тогтоомж, Хорооноос баталсан дүрэм журмыг мөрдөх;
- 10.7.2. Ил тод, шударга, мэргэжлийн өндөр ёс зүйтэй байх;
- 10.7.3. Иргэн, байгууллагын нууцыг хадгалах, хамгаалах;
- 10.7.4. Ашиг сонирхолын зөрчлөөс зайлсхийх.

### **Арван нэг. Бүртгүүлэхэд тавигдах шаардлага**

11.1. Бүртгүүлэхийг хүсч буй МНБ нь дараах нөхцөл шаардлагыг хнгасан байна. Үүнд:

11.1.1 Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институт /цаашид “ММНБИ” гэх/-ийн гишүүнчлэлтэй, Монгол улсад бүртгэлтэй хугацаагүй эрхтэй мэргэшсэн нягтлан бодогч байх;

11.1.2. Мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаж байгаагүй, энэ талаар ММНБИ-ээс тодорхойлолт гаргуулсан байх;

11.1.3. Үнэт цаасны зах зээлд хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх авсан байх;

11.2. МНБ нь бүрэн эрхээ гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх бөгөөд ХОМК-тай гэрээ байгуулсан байна.

11.3. МНБ нь журмын 4.1-д заасан шаардлагыг ханган Хороонд бүртгүүлснээр хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, мэргэжлийн үйлчилгээ үзүүлнэ.

### **Арван хоёр. Бүртгэх, хугацааг сунгах, бүртгэлээс хасах**

#### ***12.1. Хороонд бүртгүүлэх хүсэлт гаргах:***

12.1.1. Хороонд бүртгүүлэхийг хүссэн МНБ нь энэхүү журмын хоёрдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргасан өргөдлийг хоёрдугаар хавсралтад заасан хавсаргах баримт бичгийн хамт Хороонд хэвлэмэл болон цахимаар ирүүлнэ.

12.1.2. Хороо тухайн бүртгүүлэхийг хүссэн МНБ-оос ирүүлсэн өргөдөл, баримт бичгийн бүрдлийг шалгаж, баримт хүлээн аьснаас хойш ажлын 15 хоногийн дотор Хорооны удирдлагад танилцуулж, Хорооны даргын тушаалаар шийдвэрлэнэ.

12.1.3. Хороо МНБ-ийг шаардлага хангасан гэж үзвэл Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, ХОМК-д үйлчилгээ үзүүлэх этгээдээр бүртгэнэ.

#### ***12.2. Хороонд бүртгүүлсэн МНБ-ийн бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлийг сунгах, бүртгэлээс хасуулах хүсэлт гаргах, бүртгэлээс хасах:***

12.2.1. Бүртгэлийн хугацаа дуусахаас нэг сарын өмнө хугацааг сунгуулах хүсэлтийг энэхүү журамд заасан шаардлагыг хангасан баримт бичгийн хамт Хороонд бичгээр ирүүлнэ.

12.2.2. Бүртгэлийн хугацаа сунгуулах тухай хүсэлтийг Хорооны Ажлын алба тухайн мэргэшсэн нягтлан бодогчийн ажлын гүйцэтгэлийн дүн, чанар байдлыг харгалзан холбогдох шийдвэрийн төсөл боловсруулж Хороогоор шийдвэрлүүлнэ.

12.2.3. Бүртгэгдсэн этгээдийг өөрийн хүсэлтээр болон дор дурдсан зөрчил дутагдал гаргасан нь тогтоогдвол Хороо бүртгэлээс хасна. Үүнд:

12.2.3.а. Энэхүү журмын 11 дүгээр бүлэгт заасан нөхцөл шаардлагын аль нэг нь хангагдахгүй болсон;

12.2.3.б. Бүртгүүлэхдээ хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;

12.2.3.в. Санхүүгийн тайланг буруу тайлагнасан, дагаж мөрдвөл зохих дүрэм, журам үйл ажиллагаанд баримтлах зармыг зөрчсөн, үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд хохирол учруулсан, түүнтэй адилтгах нөхцөл байдал үүсгэсэн;

12.2.3.г. Хороо ашиг сонирхолын зөрчил бүхий нөхцөл байдал бий болсон гэж үзсэн;

12.2.3.д. Холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн нь тогтоогдсон.

12.2.4. Энэхүү журмын 12.2.3.а-д зааснаас бусад үндэслэлээр бүртгэлээс хасагдсан этгээд бүртгэлээс хасагдсанаас хойш 1 жилийн хугацаанд Хороо дахин бүртгэхээс татгалзана.

12.2.5. Хороо энэхүү журамд заасны дагуу хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг хөтлөх, ХОМК-д үйлчилгээ үзүүлэх этгээдийг бүртгэлээс хасах, хөрөнгө

оруулалтын сангийн тухай хууль болон холбогдох бусад тогтоомжийг зөрчсөн этгээдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулах олон нийтэд мэдээлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

12.3. Хороонд бүртгүүлсэн МНБ нь Хорооноос зөвшөөрсөн хугацаанд үйлчилгээ үзүүлэх эрхтэй байна.

12.4. Хорооны тусгай зөвшөөрөл, эрхийн нэгдсэн бүртгэл хариуцсан ажилтан нь МНБ-ийг бүртгэсэн, хугацааг нь сунгасан, бүртгэлээс хасагдсан талаарх дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, Хорооны Үнэт цаасны салбар хариуцсан нэгжид өөрчлөлт орсон тухай бүр мэдэгдэнэ.

12.5. Хороо нь шинээр бүртгэх, хугацааг нь сунгахаас татгалзах тохиолдолд үндэслэлээ хүсэлт гаргасан этгээдэд албан ёсоор хүргүүлнэ.

12.6. МНБ-ийн үйлчилгээ үзүүлэх этгээдийг шинээр бүртгэсэн, хугацааг нь сунгасан, бүртгэлээс хасагдсан тухай шийдвэрийг шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан Хорооны цахим сүлжээгээр дамжуулан олон нийтэд мэдээлнэ.

12.7. МНБ нь бүртгэлтэй хугацаандаа ММНБИ-ийн мэргэжлийн ёс зүйн алдаа дутагдал гаргаагүй талаарх тодорхойлолтыг жил бүр Хороонд ирүүлнэ.

### **Арван гурав. Санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрөх**

13.1. Хороонд бүртгүүлсэн МНБ-ийн хөрөнгө оруулалтын санийн санхүүгийн тайланд Хорооны Үнэт цаасны хяналт, шалгалтын нэгж хяналт тавина.

13.2. Хороонд бүртгэлгүй болон энэхүү журмын шаардлагыг хангаагүй нь тогтоогдсон этгээдийн гаргасан санхүүгийн тайланг Хороо хүлээн зөвшөөрөхгүй.

## **ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ**

### **БҮЛЭГ 3 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ТАВИХ**

#### **Арван дөрөв. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, бүтэц зохион байгуулалт (зөвхөн хамтын)**

14.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн эрх барих дээд байгууллага нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал байна.

14.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд тухайн сангийн нэгж эрх эзэмшигч иргэн, хуулийн этгээд оролцох эрхтэй байна.

14.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд нэг нэгж эрх тус бүр нэг саналын эрхтэй байх ба нэгж эрх эзэмшигч иргэн, хуулийн этгээд тус бүрийн саналын эрх нь тэдгээрийн тус бүрийн өмчлөл, эзэмшил дэх нэгж эрхийн тоогоор тодорхойлогдоно.

14.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл нэг адил хамаарах ба хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бусад бүрэн эрхийг уг зүйлд нийцүүлэн тодорхойлно.

14.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заах сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд дараах бүрэн эрхийг заавал тусгана:

14.5.1. менежментийн компанийг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

14.5.2. кастодианыг сонгох, хөрөнгө хадгалах гэрээ байгуулах шийдвэр гаргах;

14.5.3. төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох;

14.5.4. менежментийн компани болон кастодианы төлбөр, урамшууллын дээд хязгаарыг тогтоох;

14.5.5. бусад.

14.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хөрөнгө оруулалтын сангийн эрх барих байгууллага байна.

14.7. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөл нь 5-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх шаардлагын хүрээнд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоог тухайн сангийн гишүүдийн хурлаас сангийн дүрэмд заах замаар тодорхойлно.

14.8. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байх ба хараат бус гишүүн нь Компанийн тухай хуулийн 79.1-д заасан шалгуурыг хангасан байна.

14.9. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийг Компанийн тухай хууль болон Хорооноос баталсан журмын дагуу сонгоно.

14.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд үндэслэн сангийн дүрмээр тодорхойлно.

14.11. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагын эрх хэмжээний хуваарийг тухайн сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас батлах ба гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэр хэмжээг уг хуваарийн хүрээнд гүйцэтгэх удирдлагатай байгуулах гэрээгээр тогтооно. Гүйцэтгэх удирдлагатай гэрээ байгуулах шийдвэрийг тухайн сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гаргана.

14.12. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх удирдлага эрхлэх бөгөөд уг бүрэн эрхийг хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний үндсэн дээр менежментийн компани өөрөө эсхүл уг менежментийн компаниас томилсон эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлнэ.

14.13. Энэхүү журмын 2.12-д заасан менежментийн компаниас томилох эрх бүхий албан тушаалтан болон бусад ажилтан нь тухайн сангийн тухайд тохиромжтой этгээд байна.

### **Арван тав. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал**

14.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах, шийдвэр гаргахтай холбоотой харилцаанд Компанийн тухай хуулийн холбогдох заалт нэг адил үйлчилнэ.

14.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд уг хурлыг хуралдуулбал зохих хугацаа өнгөрсөн өдрөөс эхлэн тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх дуусгавар болсонд тооцох ба тэдгээрийн байгуулсан аливаа гэрээ, хэлцэл, гаргасан шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

14.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулахаас өмнө сангийн нэгж эрх эзэмшигчдэд хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах баримт бичигтэй танилцах боломжоор хангах үүрэг хүлээнэ:

14.3.1. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлан;

14.3.2. санхүүгийн жилийн тайлангийн талаар аудитын байгууллагаас гаргасан дүгнэлт;

14.3.3. кастодианы хөрөнгө хадгалах үйлчилгээний жилийн тайлан;

14.3.4. менежментийн компанийн хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээний жилийн тайлан;

14.3.5. хөрөнгө оруулалтын сангийн урсгал зардал, цалин, урамшууллын талаарх мэдээлэл;

14.3.6. хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан бусад.

14.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хурлаар тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар төлөөлөн удирдах зөвлөл болон менежментийн компанийн дүгнэлтийг заавал хэлэлцэнэ.

14.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч нь сангийн гүйцэтгэх удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлд сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах хүсэлтийг хэдийд ч тавьж болох бөгөөд тухайн хуралд хэлэлцэх асуудлыг тусгасан, хурал болох өдөр, цагийг болон нэгж эрх эзэмшигчдийн 5-аас багагүй хувь нь зөвшөөрсөн гарын үсэг бүхий хүсэлтийг тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн байранд хүргүүлсэн байна.

14.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдсон зардлыг сан бүрэн хариуцана.

14.7. Дараах тохиолдолд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг заавал зарлан хуралдуулна:

14.7.1. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны явцад хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активын хэмжээ нь дараалсан 10 хоногийн туршид тухайн сан үйл ажиллагаагаа эхлүүлсэн өдрийн хэмжээнээс 40 хувь, эсхүл түүнээс илүү хувь хэмжээгээр буурсан;

14.7.2. хөрөнгө оруулалтын менежментийн компани татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний эрх, үүргийг эрх бүхий өөр хөрөнгө оруулалтын менежментийн компанид шилжүүлэх шаардлага үүссэн;

14.7.3. кастодиан татан буугдах, дампуурах нөхцөл байдал бий болсны улмаас хөрөнгө хадгалах гэрээний эрх, үүрийг эрх бүхий өөр кастодианд шилжүүлэх шаардлага үүссэн;

14.7.4. хөрөнгө оруулалтын сангийн бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг нь тухайн сангийн цэвэр активыг энэ журмын 7.4-т заасан хэмжээнээс болон энэхүү журмын 3.7.1-д заасан хэмжээнээс их хэмжээгээр буурах нөхцөл байдал үүссэн;

14.7.5. хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианыг сонгох, хөрөнгө итгэмжлэн удирдах болон хөрөнгө хадгалах гэрээний эрхийг шилжүүлэх энэхүү журмын 3.7.2, 3.7.3-т зааснаас өөр бусад нөхцөл байдал, шаардлага бий болсон;

14.7.6. аудитын хорооноос хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурал хийхийг шаардсан;

14.7.7. дүрэмд заасан бусад тохиолдол.

14.8. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл гүйцэтгэх удирдлага буюу менежментийн компани нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит бус хурлыг хуралдуулах тухай санал, шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдөрт багтан сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хуралдуулах шийдвэрийг гаргах ба тухайн нөхцөл байдалд нийцүүлэн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хамгаалах шаардлагатай арга хэмжээг нэн даруй хэрэгжүүлэх үүрэгтэй байна.

14.9. Энэ журмын 3.8-д заасны дагуу сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаар шийдвэрлэсэн тохиолдолд хурлыг хурал хуралдуулах шийдвэр гаргасан өдрөөс хойш 45 хоногийн дотор хуралдуулна.

14.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал болох өдрөөс 14 ба түүнээс дээш хоногийн өмнө хурал зохион байгуулагч этгээд нь хурлын тов болон холбогдох мэдээллийг бичгээр болон цахим шуудангаар хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд хүргүүлнэ.

14.11. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нийт гаргасан нэгж эрхийн 50 хувиас дээш хувийг эзэмшигчид оролцсоноор сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын ирцийг бүрдсэн гэж үзэж тухайн хурал хүчин төгөлдөр болно.

14.12. Энэхүү журмын 3.11-д заасан ирц бүрдээгүй бол хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөр бус гэж үзэн тухайн хурлыг хойшлуулж, дахин хуралдах өдрийг товлох бөгөөд энэ тохиолдолд өмнө зарласан хэлэлцэх асуудлыг өөрчлөхийг хориглох ба сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг дахин хуралдуулахтай холбоотой харилцааг сангийн нэгж эрх эзэмшигчдийн дүрмээр зохицуулна.

14.13. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зохион байгуулагч нь бүх нэгж эрх эзэмшигчдэд хурлын үйл явцыг хүртээмжтэй байдлаар зохион байгуулах ба дараах нөхцлийг заавал хангасан байна:

14.13.1. саналын эрхийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх;

14.13.2. асуулт асуух, хариулт авах;

14.13.3. итгэмжлэлийн үндсэн дээр санал өгөх боломжоор хангах;

14.13.4. хурлын явцын талаар тэмдэглэл хөтлөх;

14.13.5. эзэмшиж буй нэгж эрхийн төрөл, хувилбарт үндэслэн адил нэгж эрх эзэмшигчид хуралдах, зөвлөлдөх боломжоор хангах.

14.14. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралтай холбоотой бусад харилцааг Компанийн тухай хууль болон сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас тогтоосон дүрэм, журмаар нарийвчлан зохицуулна.

14.15. Хамтын хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж байгаа менежментийн компанийн зүгээс тухайн санд томилон ажиллуулж байгаа эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд нь өөрийн өмчлөл дэх нэгж эрх эзэмшигчийн хувиар хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд саналын эрх эдлэхгүй. Энэхүү заалт нь итгэмжлэгдсэн этгээдийн хувиар бусдыг төлөөлөн гишүүдийн хуралд оролцох, саналын эрх эдлэхэд хамаарахгүй.

### **Арван зургаа. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал**

16.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд ойрын хугацаанд хуралдахаар заагаагүй бол хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг сард нэгээс доошгүй удаа хуралдуулах бөгөөд шаардлагатай гэж үзвэл нэмэлт хурал хийж болно.

16.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын дарга гарын үсэг зурна.

16.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, түүний гишүүд, гүйцэтгэх удирдлага болон хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд заасан бусад этгээдийн санаачилга, шаардлагаар хуралдуулна.

16.4. Төлөөлөн удирдах зөвлөл нь өөрийн үйл ажиллагааны журмыг батлан мөрдөх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөл нь эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болно.

16.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож байгаа төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн бүр саналын нэг эрхтэй байна.

16.6. Хуульд өөрөөр заагаагүй, эсхүл хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрмээр тусгайлан өндөр хувь тогтоогоогүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

16.7. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд Компанийн тухай хуулийн 80.11-д заасан зүйлийг бүрэн тусгах ба уг тэмдэглэлд хуралд оролцсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд гарын үсэг зурах бөгөөд тухайн тэмдэглэлийн үнэн зөвийг тухайн хурлын дарга хариуцна.

16.8. Төлөөлөн удирдах зөвлөлийн аль нэг гишүүн төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргана.

16.9. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гаргасан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.

### **Арван долоо. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага**

17.1. Хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагын чиг үүргийг хөрөнгө оруулалтын менежментийн компани буюу тухайн хөрөнгө оруулалтын менежментийн компаниас томилсон хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий албан тушаалтан хэрэгжүүлэх бөгөөд уг ажилтан нь хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээний хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу тухайн хөрөнгө оруулалтын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.

17.2. Энэхүү журмын 5.1-д заасан эрх бүхий албан тушаалтан нь хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх захирлын эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

17.3. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно.

17.4. Энэхүү журмын 5.1-д заасан гэрээнд төлөөлөн удирдах зөвлөлийг төлөөлж, төлөөлөн удирдах зөвлөлийн дарга гарын үсэг зурах бөгөөд гэрээнд гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг, хариуцлагын хэмжээ, хязгаар, хариуцлагаас чөлөөлөх үндэслэл, хөлс, урамшуулал зэрэг асуудлыг тусгасан байна.

17.5. Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлөөс олгосон эрх хэмжээний хүрээнд хэлцэл хийх, гэрээ байгуулах, хөрөнгө оруулалтын санг төлөөлөх зэргээр хөрөнгө оруулалтын сангийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

17.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд уг багтай гэрээ байгуулах, уг багын үйл ажиллагааг зохицуулах болон хариуцлага хүлээхтэй холбоотой харилцааг Компанийн тухай хуулийн 83.9-83.13 дахь хэсгийн хүрээнд зохицуулна.

17.7. Гүйцэтгэх удирдлагын бүрэн эрхийг зогсоох шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөл хэдийд ч гаргах эрхтэй.

17.8. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагад Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн хүрээнд хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх эрх аваагүй аливаа этгээдийг ажиллуулахыг хориглоно.

17.9. Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн аюулгүй хадгалалтын талаар хөрөнгө оруулалтын менежментийн компанийн байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан үүрэг гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтанд нэг адил хамаарна.

17.10. Гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан, ажилтан нь энэхүү журмын 5.10-д заасан шаардлагын хүрээнд дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

17.10.1. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг эрх бүхий кастодианд хадгалуулах арга хэмжээ авах;

17.10.2. Хорооноос болон эрх бүхий төрийн байгууллагаас баталсан дүрэм, журмын хүрээнд үйл ажиллагаа явуулах, хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ, тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа дотоод журмын хүрээнд хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэх;

17.10.3. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын багцийн менежмент болон сангийн бүх удирдлагын үйл ажиллагааг тухайн сангийн дүрэм, журам болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэх;

17.10.4. хөрөнгө оруулалт хийх боломжтой байгаа хөрөнгийн төрлийн талаар сангийн төлөөлөн удирдах зөвлөлд зөвлөх;

17.10.5. хөрөнгө оруулалтын оновчтой бодлого боловсруулах;

17.10.6. хөрөнгө оруулалтын бодлогын дагуу хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр хөрөнгө оруулалт хийх;



- 17.10.7. хөрөнгө ашиглалтыг нэмэгдүүлэх, яаралтай гүйцэтгэх төлбөр хураамж зэрэг зарлагад шаардагдаагүй орлогыг дахин хөрөнгө оруулалтанд оруулах;
- 17.10.8. кастодианы хадгалалтад шилжүүлэх хөрөнгийг кастодианаас тодорхойлсон хэлбэр, горимын дагуу шилжүүлэх;
- 17.10.9. сангийн нэгж эрх, үнэт цаасны үнийг сангийн дүрэм журам, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор тогтоох нөхцлийг хангах, зохих ёсоор тогтоогоогүй үнийн нөхцлөөр аливаа хувьцаа, нэгж эрхийг борлуулахгүй байх үүрэгтэй бөгөөд эдгээрийг зөрчсөн тохиолдолд бусдад учруулсан хохирол эсхүл нөхөн төлбөрийг хөрөнгө оруулалтын менежментийн компани нь өөрийн хөрөнгөөр хариуцна;
- 17.10.10. нээлттэй хөрөнгө оруулалтын сангийн тухайд хууль тогтоомж, сангийн дүрэм журмын үрээнд нэгж эрх эзэмшигчийн хүсэлтээр түүний өмчлөл дэх нэгж эрхийг хөрөнгө оруулалтын санд буцаан худалдаж авах;
- 17.10.11. хамтын хөрөнгө оруулалтын сан нь өөрийн нэгж эрхийн үнийг улсын хэмжээнд борлуулалт бүхий өдөр тутмын хоёроос дээш тооны сонин хэвлэлд болон өөрийн цахим хуудсаар өдөр бүр нийтлэн нийтэд мэдээлэл өгөх;
- 17.10.12. төлөөлөн удирдах зөвлөл болон уг зөвлөлөөс томилсон аудиторт тухайн сангийн нягтлан бодох болон бусад бүртгэл, дансны хөтлөлтийг гарган өгөх, шаардлагатай тайлбар, мэдээлэл, тодруулгыг тухай бүр саадгүй өгч ажиллах;
- 17.10.13. үүргээ биелүүлж байх явцад үүсч болзошгүй аливаа сонирхлын зөрчлийн асуудалд шударга, тэгш байр суурьтай байх;
- 17.10.14. сангийн эрх барих байгууллагын шийдвэр, бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хөрөнгө хадгалах, хөрөнгө удирдах болон зөвлөх үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой аливаа гэрээ, хэлцлийг тухайн сангийн нэрийн өмнөөс байгуулахгүй байх (энэхүү заалт нь журмын 5.6-д заасан хөрөнгө оруулалтын санг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхэд хамаарахгүй бөгөөд холбогдох гэрээ хэлцлийг байгуулах эрх нь сангийн дүрэм, журмын дагуу нэгж эрх эзэмшигчдийн хурал эсхүл төлөөлөн удирдах зөвлөлөөс шийдвэр гаргаснаар буюу зөвшөөрөл өгснөөр үүснэ);
- 17.10.15. нэгээс дээш тооны хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж байгаа нөхцөлд тэдгээрийн хооронд шударга, тэгш хуваарилалтыг гүйцэтгэж байх, шийдвэр нь хөрөнгө оруулалтын сан тус бүрийн хамгийн сүүлийн хүчин төгөлдөр хөрөнгө оруулалтын бодлого, дүрэм, журамд нийцүүлж байх;
- 17.11. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага нь сүүлийн 6 жилийн хугацаанд эзэмшсэн, буцаан худалдаж авсан, хүчингүй болгосон нэгж эрх, түүний багц, төрлийн нарийвчилсан бүртгэл, үлдэгдлийн тооцоог холбогдох үнэлгээний аргачлал, тооцооллын хамтаар хөтлөн тухайн сан дээр хадгалах ба уг бүртгэлийг үнэт цаасны төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээр давхар гүйцэтгүүлнэ.
- 17.12. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага нь энэхүү журмын 5.12-т заасан бүртгэлийг Хороо, тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөл, хөрөнгө хадгалах үйлчилгээ үзүүлж байгаа кастодианаас ирүүлэх хүсэлт, шаардлагын дагуу үнэ төлбөргүйгээр танилцуулах, холбогдох хэсгийг цахим болон хэвлэмэл хэлбэрээр гаргаж өгөх үүрэгтэй.
- 17.13. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлагыг дараах тохиолдолд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр ажлаас чөлөөлж болно:
- 17.13.1. шүүхээс үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компанийг татан буулгах тухай шийдвэр гаргасан бол;
- 17.13.2. сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын олонхийн саналаар гүйцэтгэх удирдлагыг чөлөөлөх эсхүл менежментийн компанитай байгуулсан гэрээг цуцлах, дуусгавар болгох шийдвэр гаргасан;
- 17.13.3. Хорооноос эрх хүлээн авагчийг томилсон;

17.13.4. тухайн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм болон гэрээнд заасан бусад үндэслэл.

17.13.5. Хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний салбар гишүүн компани, ажиллагсдын зүгээс санаатайгаар хүлээсэн үүргээ зөрчин гэмт хэргийн сэдэлтэйгээр сангийн хөрөнгөд хохирол учруулснаас бусад тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагаатай хамааралгүйгээр бий болсон хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө, нэгж эрх болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийн бууралтын улмаас учирсан алдагдалыг менежментийн компани хариуцахгүй.

### **Арван найм. Нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл, түүний эрх, үүрэг**

18.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийг тухайн сангаас шууд худалдан авсан эсхүл уг сангийн гаргасан нэгж эрхийг хоёрдогч зах зээл дээрээс өөрийн хууль ёсны өмчлөлд шилжүүлэн авч нэгж эрх эзэмшигчдийн бүртгэлд бүртгүүлсэн иргэн, хуулийн этгээдийг нэгж эрх эзэмшигч гэнэ.

18.2. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрхийг төлбөргүйгээр эсхүл дараа төлөгдөх нөхцлөөр бусдын өмчлөлд шилжүүлэхийг хориглоно.

18.3. Нэгж эрх эзэмшигчдийн тухайлсан бүртгэлийг хөрөнгө оруулалтын менежментийн компани хөтлөх бөгөөд уг бүртгэлд дараах мэдээллийг тусгана:

18.3.1. Компанийн тухай хуулийн 45.3-т заасан мэдээлэл;

18.3.2. нэгж эрх эзэмшигчийн эзэмшиж буй нэгж эрхийн бүртгэлд бүртгүүлсэн огноо.

18.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага нь гэрээний үндсэн дээр нэгж эрх эзэмшигчдийн тухайлсан бүртгэлийн үнэт цаасны төлбөр, тооцоо гүйцэтгэх эрх бүхий этгээдээр гүйцэтгүүлж болно.

18.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага нь хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд нэгж эрх эзэмшигчдийн бүтэц, тухайн сангийн нийт гаргасан нэгж эрхийн 5 хувь ба түүнээс дээш хэмжээний нэгж эрхийг эзэмшигчдийн жагсаалтыг тусган нийт нэгж эрх эзэмшигчдэд мэдэгдэх үүрэгтэй.

18.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид нь дараах эрхийг эдэлж үүргийг хүлээнэ:

18.6.1. сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Компанийн тухай хуульд заасан хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийн зохицуулалт хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид нэг адил хамаарна;

18.6.2. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах хүсэлтийг сангийн гүйцэтгэх удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалтан, төлөөлөн удирдах зөвлөлд гаргах;

18.6.3. хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодианы үйл ажиллагааг зогсоох, түүнийг өөрчлөх тухай асуудлыг төлөөлөн удирдах зөвлөл эсхүл сангийн гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх санал гаргах;

18.6.4. хууль тогтоомжид заасан бусад.

### **Арван ес. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө ба хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа**

19.1 Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө нь тухайн сангийн актив хөрөнгөөс бүрдэх бөгөөд сангийн актив хөрөнгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 4.1.4-т заасны дагуу тодорхойлно.

19.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активт Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1-26.1.3, 26.1.5, 26.1.8-д заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл байж болно.

19.3. Энэхүү журмын 19.2-т заасан хязгаарын хүрээнд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуулиар зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгслийг тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүнд оруулахгүй байхаар шийдвэрлэж болно. Энэ тохиолдолд тухайн хязгаарлалтын талаар хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд тусгана.

19.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нийтээс татан төвлөрүүлэх активын доод хэмжээ нь 1 тэрбум төгрөгөөс доошгүй байна.

19.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активт дараах нийтлэг шаардлага тавина:

19.5.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.2-т заасны дагуу Хорооноос тогтоосон хөрөнгө оруулалтын сангийн активт тавих нийтлэг шаардлага, зохистой харьцааны шалгуурыг болон хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийн талаар Хорооноос баталсан журмын хэрэгжилтийг хангаж ажиллах;

19.5.3. актив нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах хэрэгсэл биш байх;

19.5.4. актив дахь хөрөнгө нь эрхийн доголдол болон зөрчилгүй байх.

19.6. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийг активын бүтэцдээ оруулахыг хориглоно.

19.7. Нээлтэй хөрөнгө оруулалтын сангийн тухайд бусдаас зээл буюу зээлтэй адил шинж чанар, нөхцөл бүхий санхүүжилт авахыг хориглоно.

19.8. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь бусдад мөнгөн хэлбэрээр зээл олгохыг хориглоно. Үүнд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1.1, 26.1.2 болон 26.1.5, 26.1.5-д заасан санхүүгийн хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалт хамаарахгүй.

19.9. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн активыг бүрдүүлж байгаа хөрөнгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тухайн хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани болон нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгөөс тусдаа, тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэр дээр нээсэн дансанд байршуулах бөгөөд уг хөрөнгийн нягтлан бодох бүртгэл нь салангид, бие даасан байна.

19.10. Энэхүү журмын 19.9-д заасан хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын менежментийн компанийн бусдын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангахгүй.

19.11. Хамтын хөрөнгө оруулалтын гүйцэтгэх удирдлага нь тухайн сангийн хөрөнгөтэй холбоотой дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

19.11.1. сангийн хөрөнгө нь тухайн сангийн дүрэмд тусгасан болон Хорооноос тогтоосон нөхцөл шалгуурыг хангаж байгаа талаар байнгын хяналтыг хэрэгжүүлж ажиллах;

19.11.2. кастодианы үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний эрхийн хүрээнд хяналт тавих;

19.11.3. кастодианыг өөрчлөх, өөр кастодианд хөрөнгийг хадгалах эрхийг олгох тохиолдолд уг ажиллагааг эрсдэлгүй зохион байгуулах, шаардлагатай зөвлөмж, удирдлагаар хангах;

19.11.4. хөрөнгө оруулалтын сантай холбоотой хөрөнгийн бүхий л гүйлгээнд хяналт тавих, эрсдэлийг тооцох;

19.11.5. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой санхүүгийн анхан шатны бүх баримтыг үйлдсэн болон хүлээн авсан даруйд хувийг нь холбогдох санхүүгийн бүртгэлийг гүйцэтгэж байгаа мэргэшсэн нягтлан бодогч болон кастодианд хүргүүлэх;

19.11.6. Хорооны зөвшөөрөлгүйгээр өөрийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, нэгж эрх эзэмшигчдийн болон эрх бүхий албан тушаалтан, төлөөлөгчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүй байх;

19.11.7. тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, байгуулсан гэрээнд зааснаас илүү хэмжээний, эсхүл тэдгээрт заагдаагүй зардал, төлбөрийг сангийн хөрөнгөөс гүйцэтгэхгүй байх;

19.11.8. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга, журамд заасны дагуу нэгж эрх эзэмшигч гишүүдийг шийдвэр гаргахад хангалттай мэдээллээр хангаж ажиллах;

19.11.9. энэхүү журам болон Хорооноос тогтоосон бусад шаардлагыг мөрдөн ажиллах;

19.12. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн цэвэр актив хөрөнгийн үнэлгээг тухайн өдрийн арилжаа дууссанаас хойш 2 цагийн дотор тухайн сангийн цахим хуудсаар нийтэд мэдээлнэ.

19.13. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн цэвэр актив хөрөнгийн үнэлгээг Хорооноос тохиромжтой этгээд гэж үзсэн үнэлгээчин Хорооноос тогтоосон “Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активыг тооцоолох журам”-ын дагуу гүйцэтгэнэ.

19.14. Үнэлгээчин, эсхүл үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан болон аудитын компани, түүний ажилтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглоно.

19.15. Хөрөнгө хадгалах эрх бүхий кастодиан нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн болон менежментийн компанийн өмнө гэрээний дагуу сангийн хөрөнгийг итгэмжлэн хадгалах үүргийг хүлээх бөгөөд кастодианы хөрөнгө хадгалах үйл ажиллагааг Хорооноос баталсан журмын дагуу гүйцэтгэнэ.

19.16. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн бүртгэлийг гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий кастодиан хөтлөн явуулж уг ажиллагааны гүйцэтгэлийн талаар үйл ажиллагааны тайландаа тусгана.

19.17. Хамтын хөрөнгө оруулалтын санг удирдах эрх бүхий албан тушаалтан нь сангийн хөрөнгийг сангийн дүрэм, журамд зааснаас бусад зориулалтаар ашигласан хууль бус үйлдэл нь сангийн актив болон хөрөнгийн бүтцэд хамаарах хөрөнгөнд хохирол учруулсан нь тогтоогдсон бол уг хохиролыг тус албан тушаалтан өөрийн хөрөнгөөр барагдуулна.

19.18. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол сангийн хөрөнгө нь хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани, кастодиан болон тухайн сангийн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас хамааралгүйгээр буюу нийгэм, эдийн засаг, хууль, эрх зүй болон зах зээлийн хүчин зүйлсээс хамаарч буурсан, хохирол учирсан бол уг хохиролыг сангийн хөрөнгөөр барагдуулна.

19.19. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн орлого, зарлагыг тооцоолох, ашгийг тодорхойлох, төлбөр тооцоо, цалин урамшууллыг тооцох, олгох гэх зэрэг санхүү, нягтлан бодох бүртгэлийг Хорооноос тогтоосон болон холбогдох нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, журмын дагуу гүйцэтгэнэ.

19.20. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэм болон танилцуулгад тухайн хөрөнгө оруулалтын санд хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компанид төлөх төлбөр, урамшууллын тус бүрийн дүн, дээд хэмжээг заасан байх ба уг хэмжээнээс илүү хэмжээний төлбөр, урамшуулал олгохыг хориглоно.

19.21. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, нэгж эрхийн танилцуулга болон зар сурталчилгааны материалд заагаагүй бол тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс санд

үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компанид аливаа зарлага, хураамж, сурталчилгааны төлбөр төлөхгүй.

19.22. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид тухайн сангийн боловсруулсан хөрөнгө итгэмжлэн удирдах журамд үндэслэн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулснаар уг хөрөнгө оруулалтын санг төлөөлөх эрх хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний томилсон эрх бүхий албан тушаалтанд үүснэ.

19.23. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд дараах шаардлага, хязгаарлалтыг тавина:

19.23.3. энэхүү журмын 19.23.2-т заасан хөрөнгийн хэмжээг тооцохдоо уг тооцоололд тухайн эрх бүхий арилжааны банкны гаргасан үнэт цаасыг тухайн хөрөнгө оруулалтын сан эзэмшиж байгаа бол тэдгээрийн үнэт цаасны үнийн дүнг нэмэж тооцно;

19.23.6. өрийн хэрэгсэл гаргасан нэг үнэт цаас гаргагчийн нийт гаргасан өрийн хэрэгслийн нэрэлсэн үнийн 10 ба түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээгээр өрийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийхийг хориглоно;

19.23.7. Хорооноос тогтоосон бусад.

19.24. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь сангийн нэгж эрх тус бүрд оногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ нь тухайн нэгж эрхийн нэрлэсэн үнээс илүү байх нөхцөлд аливаа урамшууллыг олгож болно. Энэхүү нөхцлийг хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журам болон холбогдох гэрээнд заавал тусгана.

### **Хорь. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа**

20.1. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн активт Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 26.1-т заасан хөрөнгө оруулалтын хэрэгсэл хамаарна.

20.2. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активын үнэлгээг Хорооноос тогтоосон “хөрөнгө оруулалтын сангийн цэвэр активыг тооцоолох журам”-ын дагуу тооцоолно.

20.3. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлын шийдвэрээр хуулиар зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгслийг тухайн хөрөнгө оруулалтын сангийн активын бүрэлдэхүүнд оруулахгүй байхаар шийдвэрлэж болно.

20.4. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь санхүүгийн хөшүүрэг хэрэглэсэн, эсхүл үнэт цаасны үнийн бууралтаас ашиг хүртэх нөхцөлтэй хөрөнгө оруулалтын хэрэгслийг активын бүтэцдээ оруулж болно.

20.5. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 25.1.11-д заасан журмын дагуу хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг барьцаалан зээл авч болно.

20.6. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь дүрэмд өөрөөр заагаагүй бол бусдад мөнгөн хэлбэрээр зээл олгохыг хориглоно. Үүнд өрийн хэрэгсэлд оруулах хөрөнгө оруулалт хамаарахгүй.

20.7. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн активыг бүрдүүлж байгаа хөрөнгийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу тухайн санд үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани болон нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгөөс тусдаа, тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэр дээрх нээсэн дансанд байршуулах бөгөөд уг хөрөнгийн нягтлан бодох бүртгэл нь салангид, бие даасан байна.

20.8. Энэхүү журмын 20.7-д заасан хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалтын менежментийн компанийн бусдын өмнө хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангахгүй.

20.9. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага зэрэг эрх бүхий албан тушаалтан нь гэрээнд зааснаас гадна тухайн сангийн хөрөнгөтэй холбоотой дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

20.9.1. сангийн хөрөнгө нь тухайн сангийн дүрэмд тусгасан болон Хорооноос тогтоосон нөхцөл шаардлагад хүрч байгаа талаар байнгын хяналтыг хэрэгжүүлж ажиллах;

20.9.2. кастодианы үйл ажиллагаанд хөрөнгө итгэмжлэх гэрээнийн эрхийн хүрээнд хяналт тавих;

20.9.3. кастодианыг өөрчлөх, өөр кастодианд хөрөнгийг хадгалах тухай шийдвэр гарч уг эрхийг олгох тохиолдолд уг ажиллагааг эрсдэлгүй зохион байгуулах, шаардлагатай зөвлөмж, удирдлагаар хангах;

20.9.4. хувийн хөрөнгө оруулалтын сантай холбоотой хөрөнгийн бүхий л гүйлгээнд хяналт тавих, эрсдэлийг тооцох;

20.9.5. хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн хөдөлгөөнтэй холбоотой санхүүгийн анхан шатны бүх баримтыг үйлдсэн болон хүлээн авсан даруйдаа хувийг нь мэргэшсэн нягтлан бодогч болон кастодианд хүргүүлэх;

20.9.6. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, байгуулсан гэрээнд зааснаас илүү хэмжээний, эсхүл тэдгээрт заагдаагүй зардал, төлбөрийг сангийн хөрөнгөөр гүйцэтгэхгүй байх;

20.9.7. хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журамд заасны дагуу нэгж эрх эзэмшигчдийг шийдвэр гаргахад хангалттай мэдээллээр хангаж ажиллах;

20.9.8. энэхүү журам болон Хорооноос тогтоосон бусад шаардлагыг мөрдөн ажиллах.

20.10. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн активын үнэлгээчин, эсхүл үнэлгээ хийх эрх бүхий хуулийн этгээд нь хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан, аудитын компани, түүний ажилтан болон тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээд байхыг хориглоно.

20.11. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн бүртгэлийг хөрөнгө оруулалтын менежментийн компани болон эрх бүхий кастодиан хөтлөн явуулж уг ажиллагааны гүйцэтгэлийн талаар үйл ажиллагааны тайланд тусгана.

20.12. Хувийн хөрөнгө оруулалтын санг итгэмжлэн удирдах менежментийн компани нь сангийн хөрөнгийг сангийн дүрэмд зааснаас бусад зориулалтаар ашигласан үйлдэл нь сангийн актив болон хөрөнгийн бүтцэд хамаарах хөрөнгөд хохирол учруулсан нь тогтоогдсон бол уг хохирлыг өөрийн хөрөнгөөр барагдуулна.

20.13. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэмд өөрөөр заагаагүй бол сангийн хөрөнгө нь хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани, кастодиан болон тухайн сангийн удирдлагын буруутай үйл ажиллагаанаас хамааралгүйгээр буюу нийгэм, эдийн засаг, хууль, эрх зүй болон зах зээлийн хүчин зүйлсээс хамаарч бууран хохирол учирсан бол уг хохиролыг сангийн хөрөнгөөр барагдуулна.

20.14. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн орлого, зарлагыг тооцоолох, ашгийг тодорхойлох, төлбөр тооцоо, цалин урамшууллыг тооцох, олгох гэх зэрэг санхүү, нягтлан бодох бүртгэлийг Хорооны “Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан бэлтгэх заавар” болон холбогдох нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ.

20.15. Хувийн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид тухайн санг үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компанийн боловсруулсан хөрөнгө итгэмжлэн удирдах журамд үндэслэн хөрөнгө оруулалтын менежментийн компанитай хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ байгуулснаар уг хөрөнгө оруулалтын санг төлөөлөх эрх хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний томилсон гүйцэтгэх удирдлагад үүснэ.

20.16. Өөр бусад хөрөнгө оруулалтын сангийн гаргасан нэгж эрхийн 25 буюу түүнээс дээш хувийг эзэмшихийг хориглоно (үүнд гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан нэг адил хамаарна);

20.17. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь сангийн нэгж эрх тус бүрд оногдох цэвэр хөрөнгийн үнэлгээ нь тухайн нэгж эрхийн нэрлэсэн үнээс илүү байх нөхцөлд аливаа урамшууллыг олгож болно. Энэхүү нөхцлийг хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журам болон холбогдох гэрээнд заавал тусгана.

### **Хорин нэг. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл, аудит**

21.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг Хороонд бүртгэлтэй эрх бүхий мэргэшсэн нягтлан бодогчоор гүйцэтгүүлнэ.

21.2. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн бүртгэл, тайланг олон улсын санхүүгийн тайлангийн стандартын дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэнэ.

21.3. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь сангийн нягтлан бодох бүртгэлийг аливаа гүйлгээ, шилжүүлгийг тайлбарлахад хангалттай байх хэмжээнд хадгалах ба бүртгэл нь дараах шаардлагыг хангана.

21.3.1. хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн нөхцөл байдлын талаар тогтмол мэдээлэх боломжтой байх;

21.3.2. санхүүгийн жилийн эцэст сангийн санхүүгийн байр суурийг бүртгэх.

21.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

21.4.1. Хороо, аудитор болон санхүүгийн бусад хяналт, шалгалтанд хэдийд ч нээлтэй, шалгах боломжийг хангасан байх;

21.4.2. нягтлан бодох бүртгэлийн хуулбарыг хэвлэмэл байдлаар ажлын 2 хоногоос ихгүй хугацаанд гаргах боломжтой байх.

21.5. Хөрөнгө оруулалтын санд аудит гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах үүргийг хүлээнэ:

21.5.1. аудиторын томилгооноос өмнө санал болгож буй аудиторын ур чадвар, нөөц бололцоо, ажлын туршлага, сонирхлын зөрчилгүй, тохиромжтой этгээд мөн эсэхийг нягтална;

21.5.2. томилогдсон аудиторын нэр, ажлын хаяг, томилсон өдрийн огноо зэрэг мэдээллийг Хороонд хүргүүлэх;

21.5.3. аудиторын томилгоог цуцлах, үүрэгт ажлаас чөлөөлөх тохиолдолд уг шийдвэрийг гаргах болсон үндэслэлийн хамт Хороонд мэдэгдэх.

21.5.4. аудиторыг өөрчлөх, аудитын хяналтыг тасралтгүй байх нөхцлийг хангаж ажиллах буюу дараагийн аудитор ажлаа хүлээж авснаар өмнөх аудиторын ажил дуусгавар болох нөхцлийг хангаж ажиллах.

21.5.5. аудиторыг үүргээ гүйцэтгэхэд нь зохих туслалцааг үзүүлэх, аудиторыг ямар ч үед холбогдох бүртгэл, мэдээлэлд нэвтрэх эрхийг олгох, түүний үйл ажиллагаанд саад учруулахгүй байх;

21.5.6. аудиторыг худал, төөрөгдүүлсэн мэдээллээр хангахгүй байх, түүний үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөхгүй байх.

21.6. Аудитор нь аливаа сонирхлын зөрчилгүй байх болон тохиромжтой этгээд байх шалгуурыг хангахгүй болсон нь тогтоогдсон нөхцөлд тухайн хөрөнгө оруулалтын менежментийн

компани нь энэ талаар Хороонд шуурхай мэдэгдэх ба үүссэн нөхцөл байдлыг залруулах арга хэмжээг яаралтай авна.

21.7. Хууль тогтоомж, сангийн дүрэм, журамд өөрөөр заагаагүй бөгөөд аудитор хүлээн зөвшөөрсөн нөхцөлд аудиторын зарим чиг үүргийн өөр бусад этгээдээр хавсран гүйцэтгүүлэх буюу аутсорсинг хийж болно. Энэ нь тухайн аудиторыг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

21.8. Хөрөнгө оруулалтын сангийн аудитор нь дараахь чиг үүргийг гүйцэтгэх бөгөөд гүйцэтгэлд тухайн хөрөнгө оруулалтын санг итгэмжлэн удирдах менежментийн компани хяналт тавьж ажиллана:

21.8.1. аудит, санхүүгийн баталгаажуулалтын олон улсын стандартад заасан шаардлагын дагуу хөрөнгө оруулалтын сангийн данс, бүртгэлд аудит хийх;

21.8.2. аудитын тайланд энэхүү журмын 8.9-д заасан зүйлийг бүрэн тусгасан байх.

21.9. Хамтын хөрөнгө оруулалтын санд хийсэн аудитын тайланд дараахь зүйлсийг тусгана:

21.9.1. хамтын хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журам, хуулийн дагуу тухайн хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл нь зохих стандартын дагуу хөтлөгдсөн эсэх аудиторын дүгнэлт;

21.9.2. нягтлан бодох бүртгэл, тайлан нь тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн нөхцөл байдлыг үнэн зөвөөр илэрхийлж байгаа эсэх, цэвэр орлого, санхүүгийн жилийн эцэст тухайн сангийн хөрөнгийн цэвэр ашиг, алдагдлын хэмжээ нь үнэн зөвөөр тооцоологдсон эсэх;

21.9.3. аудиторын зүгээс нягтлан бодох бүртгэлийг зохих журмын дагуу гүйцэтгээгүй буюу нягтлан бодох бүртгэл, тайлан, үр өгөөж, алдагдлын талаар саналын зөрүүтэй зүйлс байгаа эсэх;

21.9.4. хууль тогтоомж, энэхүү журам болон Хорооноос шаардсан бусад асуудлаар өгөх санал, дүгнэлт;

21.9.5. аудитор өөрийн мэдлэг, ажлын туршлагын талаарх мэдээлэл;

21.9.6. аудит гүйцэтгэх явцад танилцуулсан мэдээлэл, баримт, материал, тайлбарын талаарх мэдээлэл, дүгнэлт;

21.9.7. тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын зүгээс болон хөрөнгө оруулалтын менежментийн компанийн зүгээс гаргасан үйл ажиллагааны тайланд тусгагдсан мэдээлэл нягтлан бодох бүртгэлтэй нийцэж байгаа эсэх талаарх дүгнэлт.

21.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн жилийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг тухайн жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд хавсаргана.

### **Хорин хоёр. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны тайлан(хамтын, хувийн)**

22.1. Хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага нь тухайн сангийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдлын талаар нэгж эрх эзэмшигчдийг мэдээллээр хангах зорилгоор сан нь үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайлан гаргана.

22.2. Хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага нь үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланг доор дурдсан хугацаанаас өмнө гаргаж Хороонд ирүүлнэ:

22.2.1. үйл ажиллагааны жилийн эцсийн тайланг тухайн санхүүгийн жил дууссаны дараа сангийн нэгж эрх эзэмшигч гишүүдийн ээлжит хурлын өмнө, тухайн жилийн эхний 4 сарын дотор;

22.2.3. үйл ажиллагааны хагас жилийн тайланг тухайн санхүүгийн жилийн 7 дугаар сарын 20-ны өдрийн дотор.



22.3. Хөрөнгө оруулалтын сан, түүний гүйцэтгэх удирдлага нь энэхүү журмаар тогтоосон үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайлан гаргах хугацаа, хуваарийг өөрчлөх эрхгүй.

22.4. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд холбогдох хугацааны санхүүгийн тайланг бүрэн эхээр нь хавсаргана.

22.5. Энэхүү журмын 22.1-д заасан үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд дараах агуулгыг тусгасан байна:

22.5.1. тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэр, хөрөнгө оруулалтын зорилго, тэдгээр зорилгод хүрэх бодлого мөн эрсдэлийн товч үнэлгээ зэрэг эрсдэлийг үнэлэх олон улсын шилдэг туршлага, зарчмын дагуу тооцоолон тусгасан байх;

22.5.2. тухайн тайлант үеийн сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа болон хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн талаарх мэдээллийг тусгасан байх;

22.5.3. хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулалтын багц (портфейл)-ын бүтэц, үнэлгээ, тэдгээр нь тайлант үеийн турш хэрхэн өөрчлөгдсөн талаар нэгж эрх эзэмшигчид дүгнэлт хийхэд шаардлагатай мэдээллийг тусгах;

22.5.4. нэгж эрх эзэмшигчдийг сангийн аливаа үйл ажиллагаа, түүний тайлангийн үеийн эцэст гарсан үр дүнд дүгнэлт, шүүмж өгөхөд шаардлагатай ач холбогдол бүхий мэдээлэл;

22.5.5. энэхүү журмын 22.4-т заасан тухайн тайлант хугацаанд хамаарах санхүүгийн тайланд үндэслэн санхүүгийн нөхцөл байдлын талаарх дүгнэлт, энэхүү журмын 22.8-д заасан харьцуулсан үзүүлэлтүүд;

22.5.6. тайлант хугацаанд хөндлөнгийн аудитын дүгнэлт гаргасан бол уг дүгнэлт, тайланг;

22.5.7. энэхүү журмын 22.7-д заасан тайлант хугацаанд хамаарах хөрөнгө оруулалтын менежментийн компанийн үйл ажиллагааны тайлан;

22.5.8. дотоод хяналтын үйл ажиллагааны тайлан;

22.5.9. тайлангийн үеийн зардлын харьцаа, харьцуулсан үзүүлэлтүүд;

22.5.10. кастодиан болон сангийн захирлуудын зөвлөлийн зүгээс тавьсан аливаа ач холбогдол бүхий асуудлын талаар тодруулга;

22.5.11. хууль, Хорооноос баталсан журам, хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журамд заасан бусад.

22.6. Энэхүү журмын 22.1, 22.2-т заасан хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланг гаргах, түгээхэд хөрөнгө оруулалтын сангийн удирдлага нь дараах шаардлагыг хангаж ажиллана:

22.6.1. ойлгомжтой, бүрэн, үнэн зөв байх бөгөөд тухайн үед хамаарах мэдээллийг бүрэн тусгасан байх

22.6.2. нэгж эрх эзэмшигчдэд үнэ төлбөргүй тараах, тухайн хөрөнгө оруулалтын сангийн цахим хуудсанд электрон хэлбэрээр үнэ төлбөргүй танилцах боломжтойгоор байршуулах;(зөвхөн хамтын)

22.6.3. Монгол хэл дээр гаргах ба нэгж эрх эзэмшигчид нь гадаад улсын иргэн, хуулийн этгээд байх нөхцөлд тэдгээр нэгж эрх эзэмшигчид хүсэлт гаргасан нөхцөлд Англи хэл дээр гаргана;

22.6.4. энэхүү журмаар тогтоосон хугацаанаас өмнө Хороонд хүргэх.

22.7. Хөрөнгө оруулалтын сан итгэмжлэн удирдах менежментийн компани нь өөрийн үйл ажиллагааны тайландаа дараах мэдээллийг тусгана:

- 22.7.1. тухайн хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын зорилго, түүний биелэлтийн талаарх мэдээлэл, үзүүлэлтүүд;
- 22.7.2. тайлант хугацаанд гүйцэтгэсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны тойм, үр дүн;
- 22.7.3. сүүлийн тайлангаас хойш сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар батлуулах шаардлага гарсан аливаа үндсэн өөрчлөлтийн талаар тодруулга;
- 22.7.4. сүүлийн тайлангаас хойш нэгж эрх эзэмшигчдээс болон Хороо, кастодианы зүгээс ирүүлсэн хүсэлт, мэдэгдэл, шаардсан аливаа өөрчлөлтийн талаар тодруулга;
- 22.7.5. нэгж эрх эзэмшигчдийг сангийн аливаа үйл ажиллагаа, явц, тайлангийн үеийн эцэст гарсан үр дүнд дүгнэлт, шүүмж өгөхөд шаардлагатай ач холбогдол бүхий мэдээлэл;
- 22.7.6. цаашид хэрэгжүүлэх арга хэмжээ, баримтлах бодлого, хүрэх үр дүнгийн талаарх мэдэгдэл.
- 22.8. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайланд энэхүү журмын 9.5.5-д заасны дагуу сүүлийн 3 жилийн хугацаанд, эсхүл үйл ажиллагаа явуулсан бүх хугацааны талаар дараахь агуулга бүхий харьцуулсан хүснэгтийг тусгана:
- 22.8.1. жил бүр, төрөл бүрээс гаргасан нэгж эрхийн хамгийн дээд болон доод үнэ;
- 22.8.2. жил бүрийн нэгж эрхэд хуваарилагдсан цэвэр орлогыг харьцуулалт хийж байгаа нийт хугацааны дундаж өгөөж, дундаж цэвэр орлоготой харьцуулсанаар;
- 22.8.3. жил бүрийн эцэс дэх сангийн хөрөнгийн нийт цэвэр активийн үнэлгээ(хамтын, хувийн);
- 22.8.4. төрөл бүрээс нэгж эрх бүрийн цэвэр активийн үнэлгээ(зөвхөн хамтын);
- 22.8.5. төлөөлөн удирдах зөвлөлийн тайланд төрөл бүрээс гаргасан нэгж эрхийн тоо(зөвхөн хамтын);
- 22.8.6. хөрөнгө оруулалтын менежментийн компанийн тайланд төрөл бүрээс одоогийн байдлаар гаргасан болон гаргасан гэж үзэж байгаа нэгж эрхийн тоо (зөвхөн хамтын);
- 22.8.7. жил бүр, төрөл бүрээс гаргасан нэгж эрхийн хамгийн дээд болон доод үнэ(зөвхөн хувийн);
- 22.8.8. жил бүрийн нэгж эрхэд хуваарилагдсан цэвэр орлого, үүнд тухайн үед гарсан нэгж эрхийн аливаа хуваагдал, нэгдэл зэргийг оруулах(зөвхөн хувийн);
- 22.8.9. тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын зорилгод орсон өөрчлөлтүүдийн талаар харьцуулалтад орсон он тус бүрийн үзүүлтэд тодруулга өгөх, орсон өөрчлөлт, үндэслэлийн талаар товч мэдээлэл(зөвхөн хувийн).
- 22.9. Энэхүү журмын 22.8-д заасан хүснэгтийг бэлдэхдээ дараах шаардлагыг баримтлана:
- 22.9.1. Сангийн үйл ажиллагааны талаар үнэн зөв дүгнэлт хийхэд саад болох буюу буруу, ташаа дүгнэлт хийхэд хүргэж болох, тийм байдалд хүрэхэд нөлөө үзүүлэхүйц аливаа бүтцийн өөрчлөлтийн зохицуулалттай холбоотой үйл ажиллагаа, үүнд бэлэн мөнгөний зорилгоор нэгж эрхийг гаргах, хүчингүй болгох зэргийг оруулахгүй;
- 22.9.2. богино хугацааны өөрчлөлт нь урт хугацааны үзүүлэлтийн үр дүнг хэт сайжирсан мэт ойлголт төрүүлэхээр бол уг нөлөөллийг харагдахуйц байдлаар харьцуулалтын нэгжийг дэлгэрүүлэх буюу тухай бүр тодруулга, тайлбар, анхааруулгыг тусгах;
- 22.9.3. тухайн хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын зорилгод орсон өөрчлөлтүүдийн талаар харьцуулалтад орсон он тус бүрийн үзүүлтэд тодруулга өгөх, орсон өөрчлөлт, үндэслэлийн талаар товч мэдээлэл өгөх.

**Хорин гурав. Хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэл, зар сурталчилгаа**

- 23.1. Хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэл нь мэдээлэл өгөх хүрээнээс хамаарч дотоод болон нийтэд өгөх мэдээллээс бүрдэнэ.
- 23.2. Хөрөнгө оруулалтын сангийн нийтэд мэдээлэх мэдээлэл нь дор дурдсан мэдээллээс бүрдэнэ:
- 23.2.1. зар сурталчилгааны мэдээлэл (зөвхөн хамтын);
  - 23.2.2. Хороонд мэдээлэх мэдээлэл
  - 23.2.3. хөрөнгийн биржид бүртгэлтэй бол хөрөнгийн биржид болон нийтэд мэдээлэх мэдээлэл;
- 23.3. Хөрөнгө оруулалтын сангийн дотоод мэдээлэл нь дор дурдсан мэдээллээс бүрдэнэ.
- 23.3.1. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд мэдээлэх мэдээлэл;
  - 23.3.2. хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлд мэдээлэх мэдээлэл;
  - 23.3.3. хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн мэдээлэх мэдээлэл;
  - 23.3.4. кастодиан, аудитор, нягтлан бодогч, үнэлгээчин, брокер, диллерийн мэдээлэл;
  - 23.3.5. хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, журамд заасан бусад мэдээлэл.
- 23.4. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн зар сурталчилгааны мэдээлэл нь хамтын хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулагч татах, тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны талаар зах зээлд мэдээлэл өгөх мэдээллийн үндсэн арга байна.
- 23.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн зар сурталчилгааны мэдээллийг нь цахим болон цаасан хэлбэрээр, Монгол хэлээр гаргах ба үүнээс гадна Англи хэлээр нийтэд мэдээлж болно.
- 23.6. Энэхүү журмын 23.5-д заасан нийтэд мэдээлэх зар сурталчилгааны мэдээллийн агуулгад энэхүү журмын 23.7, 23.8-д заасан дараах мэдээлэл багтсан байна.
- 23.7. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн баримт бичгийн талаарх мэдээлэл (зөвхөн хамтын):
- 23.7.1. хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл, сангийн хөрөнгийг үр ашигтайгаар өсгөн нэмэгдүүлэх үндэслэл, тооцоо;
  - 23.7.2. хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулалтын хэрэгслийн жагсаалт, хязгаарлалт;
  - 23.7.3. хөрөнгө оруулалтын хэрэгсэл тус бүрд хөрөнгө оруулсантай холбогдон үүсч болох эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлагын арга, хэрэгслийн тухай;
  - 23.7.4. хөрөнгө оруулалтын сангийн активын бүтцэд тавигдах шаардлага;
  - 23.7.5. хөрөнгө оруулалтын сангийн орлогоос гишүүдэд орлого хуваарилах бодлого.
- 23.8. Хөрөнгө оруулалтын сангийн тодорхойлолт:
- 23.8.1. тухайн хөрөнгө оруулалтын сангийн нэр;
  - 23.8.2. хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн албан ёсны ажлын байрны хаяг, холбогдох утас, цахим шуудангийн хаяг, факс;
  - 23.8.3. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны хүчин төгөлдөр эхлэх болон дуусгавар болох хугацаа;
  - 23.8.4. хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах этгээдийн нийтлэг нөхцөл, шаардлага болон санд оруулах хөрөнгийн доод хэмжээ;
  - 23.8.5. нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгөөр сангийн өр, төлбөрт хариуцлага хүлээлгэхгүй тухай;
  - 23.8.6. тухайн сангийн хөрөнгийн хэмжээ болон нэгж эрх эзэмшигчдийн тоо, нэрс, танилцуулга;
  - 23.8.7. менежментийн компанитай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ
  - 23.8.8. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх, түүний шинж чанар;

- 23.8.9. хөрөнгө оруулалтын сангийн эрх бүхий кастодиан түүний нэр, хаяг;
- 23.8.8. хөрөнгө оруулалтын сангийн татан буугдах журам;
- 23.8.9. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн өсөлт, бууралтын талаарх графикан мэдээлэл;
- 23.9. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн зар сурталчилгааны мэдээлэлд тавигдах ерөнхий шаардлага:
- 23.9.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 29.2-т заасны дагуу Хорооноос зөвшөөрөл авсан байх;
- 23.9.2. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 29.1-д заасан мэдээллийг тусгасан байх;
- 23.9.3. илт хуурамч, буруу, зөрүүтэй мэдээлэл болон нэгж эрх эзэмшигчдийн эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэхүйц мэдээлэл тавихгүй байх;
- 23.9.4. хөрөнгө оруулалтын санд хөрөнгө оруулах талаар хөрөнгө оруулагчдад энэ журам зааснаас бусад хэлбэрээр нийтэд сурталчлахгүй байх;
- 23.9.5. тухайн сангийн менежментийн компанийн бизнесийн нууцад хамаарах дотоод мэдээллийг мэдээлэхийг хориглоно;
- 23.9.6. сангийн гүйцэтгэх удирдлага нь санд хөрөнгө оруулах боломжтой аливаа этгээдэд маркетингийн мэдээллийг үнэ төлбөргүй гарган өгөх, зөвлөгөө өгөх үүрэгтэй;
- 23.9.7. хөрөнгө оруулалтын сангийн маркетингийн мэдээлэл нь нэгж эрхийн санал нээлттэй байх үед ирээдүйн хөрөнгө оруулагчиддаа хүртээмжтэй байлгана;
- 23.9.8. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч болохыг санал болгосон, эсвэл нэгж эрх эзэмшигч болоход нөлөөлөхүйц зар сурталчилгаа хийх, бусдаар хийлгэж болохгүй;
- 23.9.9. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигч болох хөрөнгө оруулахыг ятгах, болоход нөлөөлөхүйц мэдээлэл өгөх;
- 23.9.10. хууль тогтоомж, дүрэм журамд заасан бусад.
- 23.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нийтэд мэдээлж буй зар сурталчилгааны мэдээллээс үүсэх аливаа хөрөнгө оруулалтын менежментийн компани хариуцна.
- 23.11. Хөрөнгө оруулалтын сан нь Хороонд дараах мэдээллийг мэдээлнэ(хувийн болон хамтын):
- 23.11.1. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажилагааны жилийн эцсийн болон хагас жилийн тайлан, санхүүгийн жил, улирлын тайлан;
- 23.11.2. нэгж эрх эзэмшигчдийн бүртгэл, танилцуулга;
- 23.11.3. нэгж эрх эзэмшигчдийн эзэмшиж байгаа нэгж эрхийн төрөл, хэмжээ;
- 23.11.4. зар сурталчилгааны мэдээллийн хувь (зөвхөн хамтын);
- 23.11.5. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа холбоотой дотоод хяналтын нэгжийн гаргасан дүгнэлт;
- 23.11.6. хууль тогтоомжийн дагуу мэдээлэх шаардлагатай үнэт цаастай холбоотой хийсэн хэлцэл, арилжаа, гүйлгээний талаар болон уг хэлцэлд оролцогч талуудын талаарх мэдээлэл;
- 23.11.7. өөрийн байгууллагын үйл ажиллагаа, бүтэц, зохион байгуулалт, дүрэм, журамд орсон өөрчлөлтийг тогтоосон журмын дагуу мэдээлэх;
- 23.11.8. бусад.
- 23.12. Хороо шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 23.11-д зааснаас гадна өөр бусад мэдээллийг хөрөнгө оруулалтын сангаас гаргуулан авах эрхтэй.
- 23.13. Хөрөнгийн биржид бүртгэлтэй хамтын хөрөнгө оруулалтын сан нь хөрөнгийн биржид дараах мэдээлэл мэдээлнэ (зөвхөн хамтын):

23.13.1. зарласан нэгж эрхийн төрөл, хэлбэр, үнэ;  
23.13.2. нэгж эрхийн танилцуулга;  
23.13.3. тухайн хөрөнгө оруулалтын сангийн танилцуулга;  
23.13.4. тухайн хөрөнгийн биржийн дүрэм, журмын дагуу гаргаж өгөх, нийтэд мэдээлэхээр заасан мэдээлэл.

23.14. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд дараах мэдээлэл мэдээлнэ (хамтын болон хувийн):

23.14.1. тухайн сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны улирлын болон жилийн тайлан;

23.14.2. менежментийн компанийн үйл ажиллагааны тайлан;

23.14.3. менежментийн компанийн эрсдэлийг тооцоолсон тооцоолол;

23.14.4. кастодианы үйл ажиллагааны тайлан, дансны хуулбар;

23.14.5. үнэлгээчин, брокер дилертэй байгуулсан гэрээ, танилцуулга;

23.14.6. хяналтын хорооны дүгнэлт;

23.15. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах мэдээлэлийг мэдээлнэ (зөвхөн хамтын) :

23.15.1. менежментийн компанийн үйл ажиллагааны улирлын болон жилийн тайлан;

23.15.2. менежментийн компанийн удирдах албан тушаалтан өөрчлөгдсөн бол тэдгээрийн нэр, танилцуулга;

23.15.3. гэрээний үндсэн дээр үйлчилгээ үзүүлэгч зөвлөхүүдийн /хууль, эдийн засаг, бизнес/ танилцуулга, гэрээ;

23.16. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн талаар дараах мэдээлэлийг мэдээлнэ:

23.16.1. менежментийн компанийн ойрын болон хэтийн зорилго, зорилт;

23.16.2. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн эрсдэлийн удирдлага, тооцоолол;

23.16.3. хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг өсгөх бодлого буюу бизнес төлөвлөгөө;

23.16.4. менежментийн компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн жилийн тайлан;

23.16.5. менежментийн компанийн хүний нөөцийн мэдээлэл.

23.17. Хөрөнгө оруулалтын сангийн нийтэд мэдээлэх болон дотоод мэдээлэл үнэн бодит эсэх, мэдээллээс гарч болох эрсдэлийг тухайн хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани болон түүний томилон гүйцэтгэх удирдлагаар ажиллуулж буй хүлээнэ.

### **Хорин дөрөв. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны хяналт, зохицуулалт**

24.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны хяналт нь дараах хяналтаас бүрдэнэ:

24.1.1. дотоод хяналт;

24.1.2. аудитын хяналт;

24.1.3. Хорооноос хэрэгжүүлэх хяналт, зохицуулалт.

24.2. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хамтын хөрөнгө оруулалтын сангийн дотоод хяналтын журмын төслийг боловсруулж сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар батлуулна.

24.3. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь тухайн сангийн төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон 3-аас доошгүй гишүүнтэй дотоод хяналтын хороотой байх бөгөөд, уг хорооны

гишүүдийн нэг нь аудитын үйл ажиллагаа явуулах эрх авсан, энэ чиглэлээр 3-аас доошгүй жил ажилласан этгээд байна.

24.4. Хамтын хөрөнгө оруулалтын сан дахь дотоод хяналтыг хэрэгжүүлэх хяналтын хорооны гишүүд нь дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

24.4.1. тухайн ажилд хамааралтай, шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байх;

24.4.2. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуур хангасан байх;

24.4.3. холбогдох ажлын туршлагатай эсэх;

24.4.4. хараат бус, бие даасан, сонирхлын зөрчилгүй байх.

24.5. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хяналтын хороо нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана.

24.5.1. шударга байх;

24.5.2. тухайн ажлын байранд шаардагдсан мэрийлт, хичээл зүтгэлийг зохих түвшинд гаргах;

24.5.3. хэрэв сангийн нэгж эрх эзэмшигч болон түүний өөрийн ашиг сонирхлын хооронд зөрчил үүсвэл нэгж эрх эзэмшигчдийн сонирхлын төлөө ажиллаж, түүнд анхаарлаа хандуулна;

24.5.4. ажлын байр, ажлын байранд олж авсан мэдээллийг өөрт болон бусад хүнд давуу эрхийг бий болгохоор мөн сангийн нэгж эрх эзэмшигчдэд хохирол учруулахаар ашиглахгүй байх;

24.5.5. аудиторт үүргээ гүйцэтгэхэд нь шаардлагатай аливаа мэдээллийг гаргаж өгөх;

24.5.6. хөрөнгө оруулалтын сангийн хяналтын журамд болон дүрэмд тусгасан үүргээ биелүүлэх.

24.6. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хяналтын хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

24.6.1. хөрөнгө оруулалтын менежментийн компани нь сангийн дүрэм болон хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заагдсан үүргээ биелүүлж байгаа эсэх;

24.6.2. менежментийн компанийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж түүнд хяналт тавьж буй талаар үнэлэх;

24.6.3. кастодианы үйл ажиллагаанд хяналт тавих.

24.7. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хяналтын хороо нь өөрийн үйл ажиллагааны тайланг жилд нэг удаа гаргах бөгөөд сангий нэгж эрх эзэмшигчдийн ээлжит хуралд хөрөнгө оруулалтын сангийн жилийн тайлангийн хавсралтаар оруулж тайлагнана.

24.8. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, Хорооноос баталсан журам, заавар, сангийн дүрэм, сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах журмаар тогтоосон, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичигт заасан болон хөрөнгө оруулалтын сантай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгаад сангийн хөрөнгийг гэрээгээр хадгалж байгаа кастодиан нь хяналт тавина.

24.9. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг хадгалах кастодианы үйл ажиллагаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компанийн нягтлан бодогч тодорхой хэмжээгээр хяналт тавина.

24.10. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчид менежментийн компанийн үйл ажиллагаанд болон эрх бүхий кастодианы үйл ажиллагаанд хяналт тавих эрхтэй бөгөөд шаардлагатай гэж үзвэл гэрээгээ цуцлах эрхтэй.

24.11. Хамтын хөрөнгө оруулалтын сан дахь аудитын хяналтыг аудитын хууль тогтоомжийн хүрээнд хөндлөнгийн эрх бүхий аудитор хэрэгжүүлж, тухай бүр аудитын үйл ажиллагааны талаар тайлан, дүгнэлт гаргана.

24.12. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд тавих Хорооны хяналт нь тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа нь хууль болон түүнд нийцүүлэн гаргасан

дүрэм, журам, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавихад оршино.

24.13. Хороо хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд дараах зайны хяналтыг тавина:

24.13.1. хөрөнгө оруулалтын сангийн ээлжит хурлыг зарлан хуралдуулсан байдалд хяналт тавина;

24.13.2. хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланд хяналт тавих;

24.13.3. хөрөнгө оруулалтын сангийн мэдээлэлд хяналт тавих;

24.13.4. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны дотоод багц журамд хяналт тавих;

24.13.5. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчидээс ирүүлсэн өргөдөл гомдолд үндэслэх хяналт;

24.13.6. олон нийтийн мэдээллийн хэрэгсэлийн мэдээнд тавих хяналт;

24.13.7. харилцагчдаас ирүүлсэн гомдол, хүсэлт бусад мэдээлэлд хяналт тавих.

24.14. Хөрөнгө оруулалтын сангийн хяналтын хороо нь хорооноос шаардсан баримт, материалыг тогтоосон хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

24.15. Хорооны улсын байцаагч нь Үнэт цаасын зах зээлийн тухай хуулийн 85 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

### **Хорин тав. Хамтын хөрөнгө оруулалтын сан дахь тохиромжтой этгээдийн зохицуулалт**

25.1. Хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд оролцож байгаа дор дурдсан этгээд тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж ажиллана:

25.1.1. гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан;

25.1.2. кастодиан;

25.1.3. аудитор;

25.1.4. нягтлан бодогч;

25.1.5. үнэлгээчин;

25.1.6. хөрөнгө оруулалтын зөвлөх;

25.1.7. хуулийн зөвлөх.

25.2. Тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэхийг хамтын хөрөнгө оруулалтын сангийн өдөр тутмын үйл ажиллагааны явцад тухайн сангийн гүйцэтгэх удирдлага нягтлах үүрэгтэй бөгөөд Хороо гүйцэтгэх удирдлагаас ирүүлэх мэдээлэлд үндэслэн тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргана.

25.3. Тохиромжтой этгээдэд дараах шалгуур, шаардлагыг тавина:

25.3.1. тухайн үйл ажиллагаа, албан тушаалыг мэргэжлийн түвшинд шударгаар эрхлэх чадвартай байх;

25.3.2. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 86.1.2-т заасан хориглосон үйл ажиллагаа явуулсан эсэх /хувь хүн бол мэргэжил, мэргэшил, туршлага, эрхэлж байсан ажил, албан тушаал, түүнтэй холбоотой хариуцлага хүлээж байсан эсэх, санхүүгийн болон ёс зүйн байдал нь уг албан тушаал эрхлэхэд тохиромжтой эсэх/;

25.3.3. харилцан хамаарал бүхий этгээдийн талаарх мэдээллийг ил тод мэдээлэх, сонирхлын зөрчил бүхий үйл ажиллагаа явуулахгүй байх.

25.3.4. Хорооноос тогтоосон бусад шалгуур;

25.4. Хороо тохиромжтой этгээдийн шалгуурын хангаж байгаа эсэх талаар дүгнэлт гаргахдаа Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 68.2-т заасны дагуу дараах мэдээллийг үндэслэнэ:

25.4.1. тухайн этгээдээс ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичиг;

25.4.2. зохицуулалттай этгээдийн эрх бүхий албан тушаалтан, түүнийг албан ёсоор төлөөлж байгаа аливаа этгээдийн тухай мэдээлэл;

25.4.3. зохицуулалттай этгээд нь компанийн нэгдлийн гишүүн бол тухайн нэгдэлд хамаарах хуулийн этгээд, тэдгээрийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, холбогдох этгээд болон эрх бүхий албан тушаалтны тухай;

25.4.4. зохицуулалттай этгээд нь өөрийн үйл ажиллагааны дүрэм, журмыг тогтоосон, зүй зохистой дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын тогтолцооны тухай;

25.4.5. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад нэмэлт мэдээлэл;

25.5. Хорооноос тохиромжтой этгээдийн шалгуурыг хангаж байна гэх агуулга бүхий дүгнэлт гарган тохиромжтой этгээдээр тогтоосон этгээд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд оролцох эрх нь нээгдэнэ.

25.6. Энэхүү журмын 25.4-т заасан дүгнэлт нь тухайн этгээдийг тохиромжтой этгээд байх шалгуурыг байнга хангана гэх баталгаа болохгүй бөгөөд тухайн этгээд Хорооноос дүгнэлт гарсны дараа тохиромжтой этгээдийн шалгуурыг хангахгүй болсон, эсхүл Хороо дүгнэлт гаргах үед тодорхой бус, мэдэгдээгүй байсан нөхцөл байдал сүүлд илэрсэн бол энэ тухай үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын сангийн гүйцэтгэх удирдлага, төлөөлөн удирдах зөвлөл мэдэгдэж шийдвэр гарах хүртэлх хугацаанд үйл ажиллагаагаа түдгэлзүүлэх үүрэгтэй байна.

25.7. Энэхүү журмын 25.1-д заасан этгээд өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэйгээ гэрээ хэлцэл байгуулах тохиолдолд Компанийн тухай хуулийн 12 дугаар бүлэгт заасан журмыг баримтлана.

### **Хорин зургаа. Хөрөнгө оруулалтын санг нэгтгэх, нийлүүлэх**

26.1. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх үүрэг, хариуцлагыг өөр хөрөнгө оруулалтын санд шилжүүлэхийг хөрөнгө оруулалтын санг нэгтгэх гэнэ.

26.2. Хөрөнгө оруулалтын санг нэгтгэх шийдвэрийг гаргах эрх бүхий этгээд зөвхөн хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал байх бөгөөд нийт нэгж эрх эзэмшигчдийн дийлэнх олонхийн саналаар батална.

26.3. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар санг нэгтгэх тухай болсон шийдвэрийн төслийг болон санг нэгтгэх гэрээг нэгдэж байгаа хөрөнгө оруулалтын сан болон нэгтгэж байгаа хөрөнгө оруулалтын сан тус бүрийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар оруулж шийдвэрлүүлнэ.

26.4. Хөрөнгө оруулалтын сангийн нэгтгэх журмын төсөлд дараах зүйлсийг оруулсан байна.

26.4.1. нэгдэж байгаа сангийн үнэт цаасыг нэгтгэж байгаа сангийн үнэт цаас, болон бусад хөрөнгөд хөрвүүлэх журам;

26.4.2. кастодианы эрх шилжүүлэн авах журам;

26.4.3. хэрэв тухайн нэгдэн орж буй болон нэгтгэн авч буй хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийг итгэмжлэн удирдах эрх бүхий этгээд, өөрөөр хэлбэл тухайн хоёр сангийн үйл ажиллагааг нэг менежментийн компани удирдан явуулдаг бол нэгдэж байгаа сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ хүчин төгөлдөр бус болох бөгөөд нэгтгэн авч буй сангийн хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг тухайн менежментийн компанитай өөрчилж, дахин байгуулна;



26.5. Нэгдэж байгаа хөрөнгө оруулалтын сан тус бүрийн хурлын шийдвэрүүдээс гарсан санг нэгтгэх журам болон, гэрээ, холбогдох баримт бичгийг менежментийн компани Хороонд хүргүүлнэ.

26.6. Хороо энэхүү журмын 26.5-д заасан журам, гэрээ, холбогдох баримт бичгийг шалгаж хууль, журам зөрчөөгүй, нэгж эрх эзэмшигчдийн оруулсан хөрөнгөд хохиролгүй бол тухайн санг нэгдсэнд тооцож, нэгдэж буй сангийн тусгай зөвшөөрлийг түтгэлзүүлнэ.

26.7. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон хөрөнгийн биржийн бүртгэлээс тухайн нэгдэж орсон хөрөнгө оруулалтын сангийн нэрийг, хөрөнгө оруулалтын менежментийн компани хасуулна.

26.8. Хөрөнгө оруулалтын санг нэгтгэх үйл ажиллагаатай холбоотой гарсан бүх зардлыг сан өөрийн хөрөнгөөр хариуцана.

26.9. Хоёр буюу хэд хэдэн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг зогсоож, тэдгээрийн эрх үүрэг, хариуцлагыг шинээр бий болсон хөрөнгө оруулалтын санд шилжүүлэхийг хөрөнгө оруулалтын санг нийлүүлэх гэнэ.

26.10. Нийлж байгаа хөрөнгө оруулалтын сангийн тус бүрийн менежментийн компани нь нийлж буй хөрөнгө оруулалтын сангуудын нэгж эрх эзэмшигчдийн хурлаар дараах зүйлсийг тус тусдаа шийдвэрлүүлнэ.

26.10.1. хөрөнгө оруулалтын санг нийлүүлэх замаар өөрчлөн байгуулах тухай шийдвэрийн төсөл;

26.10.2. өөрчлөн байгуулах нөхцөл, журмыг тодорхойлсон гэрээ;

26.10.3. хөрөнгө оруулалтын сангийн шинээр бий болсон дүрэм;

26.10.4. хөрөнгө оруулалтын сан тус бүрийн үнэт цаасыг шинээр бий болсон хөрөнгө оруулалтын сангийн үнэт цаас болон хөрөнгөд хөрвүүлэх саналыг тодорхойлсон журам;

26.11. Хөрөнгө оруулалтын сангуудыг нийлүүлэх тухай шийдвэр, журам, гэрээг сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож байгаа гишүүдийн саналын дийлэнх олонхийн саналаар батална.

26.12. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар тухайн шинээр үүсэх хөрөнгө оруулалтын сангийн дүрмийг тогтоох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийг сонгоно.

26.13. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хуралд оролцож байгаа саналын эрх нь энэ журмын 26.10.4-т заасан хөрвөсөн саналын эрхтэй тэнцүү байна.

26.14. Тухайн өөрчлөн байгуулагдаж буй сангийн тус бүрийн менежментийн компани Хороонд энэхүү журмын 26.10.1-26.10.4-т заасан баримт бичгийг хүргүүлнэ.

26.15. Хороо уг баримт бичгийг хүлээн авч тухайн өөрчлөн байгуулагдаж буй сангуудын тусгай зөвшөөрлыг түтгэлзүүлнэ.

26.16. Хөрөнгө оруулалтын сангийн нийлүүлэх замаар өөрчлөн байгуулахтай холбоотой гарсан зардлыг сангийн хөрөнгөөр хариуцана.

### **Хорин долоо. Гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын санг Хороонд бүртгүүлэх**

27.1. Гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан нь Хороонд бүртгүүлсний үндсэн дээр Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 43.2, 43.3-т заасан шаардлага, хязгаарын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж болно.

27.2. Гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын санг Хороонд бүртгүүлэхэд дараах шаардлагыг тавина:

27.2.1. Хорооноос хүлээн зөвшөөрсөн санхүүгийн, эсхүл хөрөнгийн зах зээлийн зохицуулах байгууллагаас хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл, эсхүл зөвшөөрөлтэй байх;

27.2.2. Монгол Улсад хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай санхүүгийн чадавхитай байх;

27.2.3. эрх бүхий кастодиантай байх;

27.2.4. эрх бүхий албан тушаалтан нь тохиромжтой этгээд байх;

27.2.5. хөрөнгө оруулалтын сангийн хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа дагаж мөрдөх, хууль тогтоомж, журмаар тогтоосон мэдээллийг тухай бүр нийтэд, Хороонд болон хөрөнгө оруулагчдад өгч ажиллах.

27.3. Гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын санг бүртгүүлэх хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргасан байна:

27.3.1. тухайн хөрөнгө оруулалтын сангийн хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой мэдээлэл, гэрчилгээний хуулбар;

27.3.2. хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон тухай өөрийн улсын эрх бүхий төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийн хуулбар;

27.3.3. кастодиан, менежментийн компани, гүйцэтгэх удирдлага нь үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий болохыг нотлох хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн, эсхүл зөвшөөрлийн, гэрчилгээний хуулбар;

27.3.4. тухайн хөрөнгө оруулалтын сан нь Монгол улсад үйл ажиллагаа эрхлэхэд татгалзах зүйлгүй болох тухай эрх бүхий өөрийн улсын зохицуулах байгууллагаас авсан тодорхойлолт, тухайн хөрөнгө оруулалтын сангийн эрх барих байгууллагын шийдвэрийн хуулбар;

27.3.5. тухайн хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлж байгаа, удирдлагыг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээд, албан тушаалтны тодорхойлолт;

27.3.6. Хамгийн сүүлийн улирлын болон өмнөх жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хуулбар.

27.4. Хороо хүсэлтийг хүлээн авснаас хойш нэг сарын хугацаанд бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

27.5. Хороо бүртгэхээр шийдвэрлэсэн нөхцөлд Хорооны ажлын албанаас холбогдох бүртгэлийг гүйцэтгэж хүсэлт гаргагчид бичгээр хариу өгөх ба уг хариунд үйл ажиллагаа эрхлэх хүрээ, үйл ажиллагаандаа мөрдөх нөхцөл, шаардлагыг тусгасан байна.

27.6. Гадаад улсад бүртгэлтэй хөрөнгө оруулалтын сан нь Хорооны бичгээр өгсөн хариу хүлээн авсан өдрөөс үйл ажиллагаагаа Монгол Улсад эрхлэх эрх нээгдэнэ.

27.7. Хороо бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар хүсэлт гаргагчид ажлын 5 хоногийн дотор хариу мэдэгдэнэ.

### **Хорин найм. Хөрөнгө оруулалтын санг татан буулгах**

28.1. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30.1-д заасан дараах тохиолдолд хөрөнгө оруулалтын санг татан буулгана:

28.1.1. хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа явуулах хугацаа дуусгавар болсон;

28.1.2. хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас тухайн санг сайн дурын үндсэн дээр хугацаанаас өмнө татан буулгахаар шийдвэрлэсэн;

28.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд заасны дагуу хөрөнгө оруулалтын сангийн менежментийн компани хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулсан бөгөөд сангийн нэгж эрх эзэмшигчид санг татан буулгах шийдвэр гаргасан;

28.1.4. онцгой нөхцөл байдал үүссэн бөгөөд албадан татан буулгах шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон;

28.1.5. хөрөнгө оруулалтын сан дампуурсан;

28.1.6. хуульд заасан бусад;

28.2. Хөрөнгө оруулалтын санг татан буулгах шийдвэрийг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 30.2-т заасан дараахь этгээд гаргана.

28.2.1. Энэхүү журмын 28.1.1-28.1.3-т заасан үндэслэлээр хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурал;

28.2.2. Энэхүү журмын 28.1.4, 28.1.5-д заасан үндэслэлээр Хороо болон эрх бүхий бусад этгээдээс гаргасан хүсэлтийг үндэслэн шүүх;

28.2.3. Журамд заасан эрх бүхий бусад этгээд;

28.3. Хөрөнгө оруулалтын сан болон сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэх, түүнд хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх болон хөрөнгө оруулалтын санд үйлчилгээ үзүүлэх үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай этгээдэд үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг төрийн байгууллагын зүгээс тухайн сангийн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд өгөх баталгаа гэж үзэхгүй бөгөөд хөрөнгө оруулалтын сан, түүнд үйлчилгээ үзүүлж байгаа зохицуулалттай этгээдийн үйл ажиллагааны улмаас хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд болон бусдад учирсан хохирлыг төр хариуцахгүй.

28.4. Хөрөнгө оруулалтын сан өөрийн санаачлагаар татан буугдах тохиолдолд татан буулгах ажиллагааг дараах журмын дагуу гүйцэтгэнэ:

28.4.1. Тухайн хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын санг татан буулгах журмын төслийг боловсруулж, сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн татан буулгах шийдвэрийн хамт батлуулна;

28.4.2. Менежментийн компани нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гарсан татан буулгах тухай шийдвэр, татан буулгах журмыг холбогдох бичиг баримтын хамтаар Хороонд хүргүүлнэ;

28.4.3. Хороо тухайн хөрөнгө оруулалтын сангийн татан буулгахтай холбоотой материалыг шалгасны үндсэн дээр татан буулгах ажиллагааг үргэлжлүүлэх зөвшөөрлийг олгох ба тухайн санг татан буулгах ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг тавьж эхэлнэ;

28.4.4. Татан буулгах ажиллагааг үргэлжлүүлэх зөвшөөрлийг Хорооноос авсан хөрөнгө оруулалтын сан нь татан буулгах журмаа сангийн нэгж эрх эзэмшигчдэд хүргүүлэн, өөрийн мэдээллийн хэрэгслээр нийтэд ажлын 2 өдрийн дотор мэдээллэнэ;

28.4.5. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь татан буулгах шийдвэр сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас гарснаас хойш нэн даруй кастодианы үйл ажиллагааг зогсоон, хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдийн хөрөнгийг аюулгүй байдлыг хангана.;

28.4.6. Сангийн хөрөнгийг худалдан борлуулах, сангаас авлагатай этгээдийн нэхэмжлэлийн шаардлагыг хангах, сангийн бусад төлбөр тооцоог дуусгавар болгох, санг татан буулгахтай холбоотой харилцааны зардалыг сангийн хөрөнгөнөөс тухайн менежментийн компани гарган авах бөгөөд үлдсэн мөнгөн хөрөнгийг сангийн нэгж эрх эзэмшигчдийн нийлүүлсэн хувьцааны дүнд нь хувь тэнцүүлэн хуваарилна;

28.4.7. Хөрөнгө оруулалтын сангаас авлагатай этгээдээс нэхэмжлэлийг хүлээн авах хугацаа нь энэ талаар нийтэд мэдээлснээс хойш хоёр сараас багагүй, зургаан сараас илүүгүй байна;

28.4.8. Хөрөнгө оруулалтын сангаас авлагатай этгээдээс нэхэмжлэл хүлээн авах хугацаа дууссаны дараа татан буулгах үйл ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд нь сангийн нийт хөрөнгө болон төлөхөөр хүлээн зөвшөөрсөн өр төлбөрийг тусгасан санхүүгийн тайлан гаргаж Хороонд хүргүүлэх ба татан буулгах ажиллагааг менежментийн компани гүйцэтгэж байгаа бол дээрх санхүүгийн тайланг кастодианаар хянуулсан байна;

28.4.9. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах явцад уг санд төвлөрүүлэхээр тооцсон хөрөнгийн нийт дүн нь хөрөнгө итгэмжлэн удирдах журмаар тогтоосон хэмжээнд хүрээгүйгээс татан буулгаж байгаа бол татан буулгах ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд нь санд төвлөрсөн хөрөнгийг хөрөнгө оруулагчдад буцаан олгох ажиллагааг санд хөрөнгө оруулалт төвлөрүүлж дуусахаар тогтоосон хугацаа дууссанаас хойш хоёр долоо хоногийн дотор гүйцэтгэн дуусгана;

28.4.10. Менежментийн компани нь хөрөнгө оруулалтын сангийн татан буулгалтын ажиллагааг дуусгавар болсоноос хойш ажлын 5 хоногийн дотор татан буулгалтын тайланг гаргаж Хороонд хүргүүлнэ;

28.4.11. Хорооны томилсон эрх хүлээн авагч байцаагч тухайн хувийн хөрөнгө оруулалтын сангийн татан буулгалтын тайланг хянаж үзээд, аль нэгэн этгээдийн эрх ашиг хохироогүй гэж үзээд тухайн хөрөнгө оруулалтын санг татан буулгасан шийдвэр гаргана. (зөвхөн хувийн)

28.4.12. Хорооноос татан буугдсан гэж үзсэн шийдвэр гармагц, санг улсын бүртгэлээс хасуулан тухайн хөрөнгө оруулалтын сан татан буугдсанд тооцно. (зөвхөн хувийн)

28.4.13. Хороонд татан буулгалтын тайланг хүргүүлснээс хойш 30 хоногийн хугацаанд бусдаас гомдол, санал ирээгүй нөхцөлд Хороо тухайн санг татан буугдсанд тооцох бөгөөд уг шийдвэрийг үндэслэн тухайн хөрөнгө оруулалтын санг улсын бүртгэлээс хасна.(зөвхөн хамтын)

28.4.14. Хөрөнгө оруулалтын сан нь сангийн нэгж эрх эзэмшигчдийн хурлаас татан буугдах шийдвэр гаргаснаас хойш хөрөнгийн биржид нээлттэй зарласан хувьцаагаа татан авах бөгөөд хөрөнгийн биржид татан буулгах журмаа хүргүүлэн, бүртгэлээс хасуулна.(зөвхөн хамтын)

28.5. Хөрөнгө оруулалтын санг энэхүү журмын 28.1.4-т заасан үндэслэлээр татан буулгах ажиллагааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд Хороо гүйцэтгэнэ.

### **Хорин ес. Хяналт, хариуцлага**

29.1. Хороо нь үүсгэн байгуулах ажиллагааны явцад хяналт тавих, хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагаанд оролцож байгаа иргэн, хуулийн этгээдэд шаардлага, даалгавар өгөх, тэдгээрийн биелэлтийг хангуулах бүрэн эрхтэй байна.

29.2. Хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулагч хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтан болон уг ажиллагаанд оролцож байгаа иргэн, хуулийн этгээд, тэдгээрийн ажилтан нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 86.1.2 дах заалтыг үндэслэн Хорооны зүгээс гүйцэтгэх хяналт шалгалтын үйл ажиллагаанд аливаа хэлбэрээр саад хийхийг хориглоно.

29.3. Хороо нь даалгавар өгөх ажиллагааг Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 56 дугаар зүйлд нийцүүлэн хэрэгжүүлнэ.

29.4. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэгч нь хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах ажиллагааны явц, гүйцэтгэлийн талаар Хороонд мэдээлэл өгөх үүрэгтэй бөгөөд мэдээллийн төрөл, агуулга, хүрээний талаар Хороо тухай бүр чиглэл өгч ажиллана.

29.5. Хамтын хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах бичиг баримтыг Хороонд бүртгүүлснээс хойш үүсгэн байгуулах ажиллагааг зогсоосон, цуцалсан эсхүл уг үүсгэн байгуулах ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг хууль болон энэ журамд заасан хугацааны дотор сунгах хүсэлтэй бол тухайн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ талаар тухай бүр ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэгтэй. Ингэхдээ уг мэдэгдэлд үүсгэн байгуулах ажиллагааг зогсоох, цуцлах, хойшлуулах тухай шийдвэрийн үндэслэлийг дурдсан байна. (хамтын)

29.6. Хороо нь хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагаанд оролцож байгаа иргэн, хуулийн этгээдэд шаардлага, даалгавар өгөх, тэдгээрийн биелэлтийг хангуулах, хууль тогтоомж зөрчсөн бол бүртгэлийг хүчингүй болгох бүрэн эрхтэй байна. (хувийн)

29.7. Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтанд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14.6, 44.5, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 38.6, 38.7, 38.8, 40.4 болон холбогдох хууль, тогтоомж болон Хорооноос баталсан бусад журамд заасан хориглох зохицуулалт нэг адил хамаарна.

29.8. Хөрөнгө оруулалтын сангийн удирдлага, эсхүл хөрөнгө итгэмжлэн удирдах үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь дараах нөхцөл үүссэн тохиолдолд тухайн хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааг сайн дурын үндсэн дээр түдгэлзүүлж нэгж эрх эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах арга хэмжээ авах бөгөөд энэ тухай Хороонд тухай бүр мэдэгдэх үүрэгтэй. Үүнд:

29.8.1. хөрөнгө оруулалтын сангийн удирдлагын эрх бүхий албан тушаалтан, үйлчилгээ үзүүлж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани, кастодиан нь тохиромжтой этгээд биш болсон;

29.8.2. хөрөнгө оруулалтын санг татан буулгах нөхцөл байдал үүссэн;

29.8.3. нэгж эрх эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах зайлшгүй нөхцөл байдал үүссэн.

29.9. Хувийн хөрөнгө оруулалтын сан үүсгэн байгуулах баримт бичгийг Хороонд бүртгүүлснээс хойш үүсгэн байгуулах ажиллагааг зогсоосон, цуцалсан эсхүл уг үүсгэн байгуулах ажиллагааг хэрэгжүүлэх хугацааг хууль болон энэ журамд заасан хугацааны дотор сунгах хүсэлтэй бол тухайн хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын менежментийн компани нь энэ талаар тухай бүр ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэх үүрэгтэй. (хувийн)

29.10. Хороо нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагаанд оролцогч иргэн хуулийн этгээдэд Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэл ногдуулж болно.

29.11. Хөрөнгө оруулалтын менежментийн компани нь хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг эрхлэн гүйцэтгэх явцдаа санаатай, эсхүл болгоомжгүй үйлдлийн улмаас бусдад учруулсан хохирлыг болон үүсгэн байгуулж байгаа хамтын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалтын бодлогыг зөрчсөний улмаас тухайн санд учруулсан алдагдлыг тус тус өөрийн хөрөнгөөр хариуцна.

29.12. Энэхүү журмыг буцаан хэрэглэхгүй бөгөөд энэхүү журмыг баталсан Хорооны тогтоолд заасан өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

29.13. Хороонд бүртгүүлсэн мэргэшсэн нягтлан бодогчийн аливаа хууль зөрчсөн үйл ажиллагаа нь гэмт хэргийн шинжтэй гэж үзвэл Хороо хууль хяналтын байгууллагад хандаж шалгуулна.

29.14. Энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Үнэт цаасны зах зээлийн тухай, Хөрөнгө оруулалтын сангийн тухай болон бусад хууль тогтоомжид заасан захиргааны хариуцлагыг Хорооны хянан шалгагч улсын байцаагч ноогдуулна.

29.15. Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт, гэрээний зөрчилд энэхүү журмаар хариуцлага ноогдуулахгүй.

29.16. Энэ журмын 29.6, 29.14-т заасан захиргааны хариуцлага хүлээсэн нь тухайн этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

---oO---